Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл 2013. 02 сар. №02 (036) www.mongolianeconomy.mn

Дулаанхааны эвэр нум

Дундаж давхарга гэж хэн бэ?



УЛС ТӨРИЙН САВЛАГААГ БИЗНЕСИЙН ОРЧНООС ХАЛМААР БАЙНА



ТҮМЭН ХИШИГТЭН

ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ

Монгол хүний хийморь, бахдал, эр зоригийн шүтээн Их эзэн Чингис хааны олон мянган цэргүүдээс тэсвэр хатуужил, байлдах ур чадвар, үнэнч сэтгэлээрээ шилэгдэн сонгогдсон түмэн хишигтэн баатрын нэг болж өөрийн эсвэл хүндлэн хайрлаж явдаг эрхэм хүнийхээ үйл хэрэг, нэр алдрыг үеийн үед, ур хойчдоо үүрд мөнхлөн үлдээх боломжийг ТҮМЭН ХИШИГТЭН төсөл та бүхэнд олгож байна.
"Түмэн Хишигтэн"түүхэн соёл, амралтын цогцолборт байрлах түмэн хишигтэн цэргийн их аяны цуваа нь дараах бүтэцтэй байх юм.

Манлай хишигтэн
- Зүүн гарын манлай хишигтэн
- Манлай хишигтэн
- Баруун гарын манлай хишигтэн

Их гол хишигтэн
- Зүүн гарын их гол хишигтэн
- Их гол хишигтэн
- Баруун гарын их гол хишигтэн

Цагдуул хишигтэн
- Зүүн гарын цагдуул хишигтэн
- Цагдуул хишигтэн
- Баруун гарын цагдуул хишигтэн

гэсэн үндсэн 9 хэсгээс бүрдэнэ. Дээрх 9 хишигтэн баатрын хувцас хэрэглэл, морины тоноглол, зэр зэвсэг тус бүр ялгаатай байх бөгөөд бид 2 жилийн хугацаанд судалгаа, шинжилгээ хийсний үр дүнд уг загваруудыг урласан.

Эрхэм та ТҮМЭН ХИШИГТЭН төсөлд дээрх 9 загвараас сонгон хишигтэн баатрын дүрийг эзэмших байдлаар оролцох юм. Ингэснээр та болон таны ойр дотны эрхэм хүмүүн Их хааны гол хүч болох эрэлхэг түмэн дайчдын нэг болон мөнхрөх юм.

ТҮМЭН ХИШИГТЭН төсөл албан ёсоор захиалга авч эхэлсэн бөгөөд эрхэм Танд болон таны ойр дотны хүмүүст тэргүүн эгнээний * 888 * байршлыг санал болгож байна.

ТҮМЭН ХИШИГТЭН төсөлд төр, нийгэм, соёл, урлагийн нэрт зүтгэлтнүүд өөрийн хувь нэмрээ оруулаад байна. Тухайлбал:

- МУ-ын хөдөлмөрийн баатар, гавъяат тамирчин, мэргэжлийн сумогийн 68 дахь их аварга Асашорюү Д.Дагвадорж
- МУ-ын хөдөлмөрийн баатар, гавъяат тамирчин, олимпын анхны хос медальт Н.Түвшинбаяр
- МУ-ын хөдөлмөрийн баатар, гавъяат тамирчин Х.Цагаанбаатар
- МУ-ын ардын жүжигчин П.Цэрэндагва гэх мэт энэ цагийн хишигтэн баатрууд дүрээ мөнхлөөд байна.

ЭРХЭМ ТАНД Ч ЭНЭ БОЛОМЖ НЭЭЛТТЭЙ

Таны захиалга өгөх утас:
888-10000, 11-326172

Маркетингийн алба:
89099100, 89099106, 89099109, 89099111, 89099113

вэб: www.tumenkhishigten.mn

и-майл: contact@tumenkhishigten.mn

Манлай хишигтэн



Зүүн гарын манлай хишигтэн



Манлай хишигтэн



Баруун гарын манлай хишигтэн

Түмэн хишигтэн Манлай баатрууд нь дайсанд гэнэтийн цохилт өгч няцаах, гол хүчээ иртэл саатуулан барих, дайсны бөөгнөрсөн цул хүчийг сарниах, гол хүч хүртэл хуурмагаар ухарсаар дайснаа тал талаас нь бүслэн хаах, тойрч цохих үүрэгтэй байжээ.

Их гол хишигтэн



Зүүн гарын их гол хишигтэн



Их гол хишигтэн



Баруун гарын их гол хишигтэн

Манлай цэргийн ард буюу цувааны төвд байрлах их гол хэсгийн баатрууд нь тулаанд хамгийн хүчтэй, шийдвэрлэх цохилтыг өгөх үүрэгтэй байв. Чингис хаан цэргийн хүчээ их гол хэсгээс удирдах бөгөөд энэ хэсэгт дайны дөрвөн хөлт Хар Сүлд байрладаг байжээ.

Цагдуул хишигтэн



Зүүн гарын цагдуул хишигтэн




Цагдуул хишигтэн



Баруун гарын цагдуул хишигтэн

Цувааны хойно байрлах цагдуул хишигтэн нь цувааны араас дайран ирэх дайсныг илрүүлэх, дайралтыг таслан цохих үүрэгтэй байжээ. Энэ тохиолдолд цагдуул хишигтэн нь манлай болон их гол хишигтэнтэй ижил үүрэг гүйцэтгэдэг байлаа.

Түмэн хишигтэн баатрын их аяны цуваа нь түүхэн баримтанд тулгуурлагдсан бөгөөд төрийн далбаа намирч буй агуулгатай байх юм.







WORLD TRADE CENTER ULAANBAATAR

MISHEEL GROUP
EXPO · FURNITURE · BUSINESS PARK

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

MONGOLIAN STOCK EXCHANGE
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

OXFORD BUSINESS GROUP

FINANCE MONGOLIA 2013

МИШЭЭЛ ЭКСПО 2013.2.22-24

САНХҮҮГИЙН АНХДУГААР ҮЗЭСГЭЛЭН, СУРГАЛТ СЕМИНАР

САНХҮҮГИЙН БҮХ ХЭРЭГЦЭЭГ НЭГ ДОРООС

- БҮХ ТӨРЛИЙН ЗЭЭЛ
- ӨНДӨР ХҮҮТЭЙ ХАДГАЛАМЖ
- ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГА
- ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ
- ХҮҮХДИЙН МӨНГӨ
- ХУВЬЦААНЫ ДАНС НЭЭХ ...

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ СУРГАЛТ

2.23-нд
11:00-18:00

www.financemongolia.com

70111533, 95950811

WWW.UBGUIDE.MN
ОЛОТ АМЖИЛТЫГ ОЙРТУУЛАХ ХӨТӨЧ

ULAANBAATAR GUIDE SYSTEM

ФЛАЙБҮҮК ХХК

Ирж буй 17-р жарны усан Могой жилийг тохиолдуулан "Флай бүүк" ХХК-н зүгээс хамтран ажиллаж албан байгууллагуудаа болоод Улаанбаатар хотод системийн нийт хэрэглэгч нартаа сар шинийн баярын мэндийг дэвшүүлье!

Энэхүү Могой жилийн хаврын адаг сараас эхлэн Улаанбаатар хотын ирэн буй өөрийн хайж буй албан байгууллага болоод хувиараа бизнес эрхлэгчдийн мэдээллийг хүссэн газраасаа хүндрэлгүй авах, тэдгээртэй холбогдох, байгууллагуудын хөнгөлөлт урамшуулалуудын мэдээллийг харах гээд хайлтын системдээ томоохон өөрчлөлтүүдийг хийж нийгэмд нэвтрүүлэхээр зэхэж буйгаа дуулгахад таатай байна.

Нийслэл Улаанбаатар хотын ирэн буй мэдээлэлжсэн нийгмийн төлөө бидэнтэй үргэлж хамт гэдэг итгэж байна.

2013

Таны ололт амжилтыг ойртуулах хөтөч

Сар шинэдээ сайхан шинэлээрэй!

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Б.Уганбаяр
Х.Хулан
Б.Үүрийнтуяа

ОРЧУУЛАГЧ:
Ж.Түмэнбаяр
Б.Заяа

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь
ПРОГРАММИСТ: Б.Лхагвачулуун
МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /8880-0825/
Д.Баттулга /9902-2279/
Б.Энхцэцэг /9901-5476/
БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш /8870-3633/

"ECONOMY" ТВ СТУДИ

ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон
ГРАФИК ДИЗАЙН Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

MONGOLIAN ECONOMY
ОНЛАЙН ЗАХИАЛГА

www.mongolianeconomy.mn

Бизнес ямар байна вэ



Ийм асуултыг бизнесмэнүүдээс сонирхохоор “За яах вэ дээ л. Бизнесийн орчин сайн биш байна. Дотоод, гадаадын бизнес эрхлэгчид, гаднын хөрөнгө оруулагчдад хамгийн чухал нь хууль эрх зүйн орчин тогтвортой, тодорхой байх....10

Дулаанхааны эвэр нум



“Made in Mongolia” булангийн нийтлэлээ Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны “Хөвчит нум” ХХК-ийн зөвлөх Ж.Сүхбаатар, түүний хүү нум сум урлаач С.Болдбаатар нартай уулзаж бэлтгэснээ хүргэж байна...24



75

Их зөгнөөч Нострадамус “Төмөр могой дэлхийг орооно” хэмээн зүүдний тайлалдаа дурдсан байдаг. Европоос эхтэй төмөр замын сүлжээ хүмүүний амьдралын нэгэн хэсэг болсоор даруй 500 гаруй жилийг үджээ...34

Дундаж давхарга гэж хэн бэ?



Дундаж давхаргын ажлын байрны нөхцөл, баталгаат байдал, аюулгүй байдалд анхаарах шаардлагатай байна...38

БИЗНЕС

10 Бизнес ямар байна вэ
12 Улс төрийн савлагааг бизнесийн орчноос халмаар байна
24 Дулаанхааны эвэр нум
27 Эдийн засгаа НӨАТ-ийн аюулаас аварцгаая
28 Эрсдэл ба үнэлэмж

ЭДИЙН ЗАСАГ

30 Өрхийн төсөв
34 75
35 Хятадад үйлдвэрлэв 2
36 Лиценз хуулийг тунгалаг байлгаж чадах уу
38 Дундаж давхарга гэж хэн бэ?

Ì Î Í Ã Î Ë

Эрчим хүч

Монгол, Японы Засгийн газар эрчим хүчний салбарт хамтран ажиллаж, манай улсын эрчим хүчний салбарыг олон улсын жишигт хүргэхээр гэрээг үзэглэлээ. Түншлэлийн хүрээнд Японы тал Монгол Улстай хүлэмжийн хийг бууруулах, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх, дэлхийн дулаарлыг сааруулахад тодорхой хувь нэмэр оруулах төсөл хэрэгжүүлэх юм. Одоогоор эрчим хүчний хангамжын салбарт хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад шаардлагатай технологийн судалгааг талууд хийж байна.

Аялал жуулчлал

Дэлхийн зэрлэг байгалийн сан Монголын ирвэс, аргаль тэргүүтэй ховордсон амьтдын бэлчээр нутгийг дайруулан эко аялал жуулчлалын маршрут бий болгохоор



болжээ. Энэ нь хулгайн анг таслан зогсооох, зэрлэг ан амьтдаа хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, түүнчлэн нутгийн иргэдийн өрхийн орлогыг дээшлүүлэх зорилготой. Эко маршрутыг энэ онд нээхээр төлөвлөж байгаа бөгөөд Монголын баруун хэсэг Оросын хилтэй залгаа бүс нутгийг хамрах юм.

Гадаад худалдаа

Манай улсын нийт экспортын 82 хувийг ашигт малтмалын бүтээгдэхүүн эзэлж байна. Харин ашигт малтмалын экспортын 90 хувийг чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефть эзэлжээ. Нийт ашигт малтмалын экспорт өнгөрсөн онд 339 сая ам.доллараар буурч голлох бүтээгдэхүүн зэсийн баяжмалын экспорт 13, чулуун нүүрсний экспорт 17 хувиар тус тус буурчээ.

Хөдөө аж ахуй

Энэ оны төсвийн хөрөнгө оруулалтын багцад хөдөө аж ахуйн бирж байгуулахаар таван тэрбум төгрөг тусган баталлаа. Эхний ээлжинд “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит компани байгуулан, хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг туршилтаар явуулах аж. Бирж байгуулахад төрөөс нэмэлт санхүүжилт гаргалгүйгээр хувийн хэвшлийнхэн, олон улсын байгууллагуудыг татан оролцуулахаар тогтжээ.

Дэд бүтэц

Засгийн газрын хуралдаанаар “Шинэ төмөр зам” төсөлд эхний ээлжинд 55 сая ам.долларын санхүүжилт хийнэ. Энэхүү санхүүжилтийг ирэх хоёрдугаар сард багтаан олгохыг Хөгжлийн банкинд үүрэг болгосон байна. Харин зээлийн эргэн төлөлтийг тухай бүрт нь улсын төсөвт тусгаж, шийдвэрлэх болсон аж.




Банк санхүү

Монголбанкнаас арилжааны нийт 14 банкны гүйцэтгэх удирдлагуудыг хамруулсан санал асуулга явуулжээ. Санал асуулгад оролцогч нийт 11 банк буюу 79 хувь нь зээлийн хүү өндөр гэж хариулсан байна. Хүү өндөр байгаа нь эх үүсвэрийн өртөг өндөр, олдоц хомс болон эдийн засгийн нөхцөл урт хугацаанд тогтворгүй, тодорхой бус байгаатай холбоотой хэмээн тайлбарлажээ.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн бүтцийг авч үзвэл хөрөнгийн зах дунджаар 21 хувь, банкны салбар 42 хувийг эзэлдэг бол 37 хувь нь бондын захад ногдож байна. Харин манай улсын хувьд санхүүгийн зах зээлийн 90 орчим хувь нь банкны салбараас хамааралтай.

Улс орон	ЗЗҮ/ДНБ	Санхүүгийн захын бүтэц			
		Хөрөнгийн захын хувьцаа	Нэлттэй өрийн бичиг	Хаалттай өрийн бичиг	Банкны салбарын хөрөнгө
Дэлхий	87%	21%	16%	21%	42%
Европын холбоо	67%	12%	12%	24%	52%
Хойд Америк	121%	27%	17%	31%	24%
Канад	138%	29%	15%	13%	42%
АНУ	119%	27%	17%	33%	22%
Япон	75%	14%	40%	9%	38%

Өнгөрсөн 10 гаруй жилд Монгол Улсын ДНБ-ий 40 орчим хувийг хөдөө аж ахуй, уул уурхай зэрэг хөдөлмөрийн бүтээмж, нэмүү өртөг багатай салбар бүрдүүлж иржээ. Тэгвэл хөгжингүй орнуудад тус үзүүлэлт хоёр ба түүнээс бага хувийг эзэлж байна.



Эх сурвалж: ЭЗХЯ

ÄÝËÕÈÉ ÄÀÕÈÍÄ



ОУВС

Хэдийгээр улс, орнууд бодлогын хүрээнд эдийн засгаа сэргээх арга хэмжээ авч буй ч дэлхийн эдийн засгийн нөхцөл одоогийнхоос дордох магадлалтайг Олон улсын валютын сан сануулаа. Тус байгууллагын мэргэжилтнүүд өнгөрсөн аравдугаар сарын тайландаа дэлхийн эдийн засаг энэ жил 3.6 хувь, ирэх жил 4.2 хувиар өснө хэмээн таамаглаад байсан. Тэгвэл энэ удаад таамгаа 0.1 хувиар тус бууруулаад байна.

Хятад

Хятадын үйлдвэрлэл сүүлийн хоёр жилийн хугацаан дахь хамгийн өндөр өсөлтийг өнгөрсөн сард үзүүлснийг HSBC банкны мэргэжилтнүүд онцолж байна. Тус улсын үйлдвэрлэлийн захиалгын индекс өнгөрсөн оны арванхоёрдугаар сард 51.5 байсан бол удаахь сард 51.9 болж өссөнийг тус банкны тайлан харуулжээ. Индекс 50-иас дээш гарахад үйлдвэрлэл өсөж байна гэж үздэг.

Япон

Япон улсын Хятад, Европыг чиглэсэн экспорт буурснаас өнгөрсөн онд тус улс түүхэнд байгаагүй өндөр буюу 78 тэрбум ам.долларын худалдааны алдагдал хүлээжээ. Түүнчлэн тус тус мөнгөн тэмдэгтийн ханшаа сулруулах замаар экспортоо тэтгэх гэж буй нь ижил төрлийн бараа, бүтээгдэхүүн экспортолдог Өмнөд Солонгост хүндхэн цохилт болно гэж мэргэжилтнүүд үзэж байна

Их Британи

Их Британийн эдийн засаг өнгөрөгч оны сүүлийн гурван сарын турш буурсан үзүүлэлттэй байлаа. Энэ нь эдийн засгийн уналтад хүргэж магадгүй гэсэн болгоомжлолыг төрүүлээд буй. Тус улсын Үндэсний статистикийн төв эдийн засгийн өсөлтөд гарсан ерөнхий бууралтыг 0.3 хувь хэмээн тооцоолжээ. Их Британийн эдийн засаг өнгөрсөн оны гуравдугаар улиралд Лондоны зуны



олимпоос үүдэн 0.9 хувийн өсөлттэй гарсан.

Орос

Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас хоёр жилд нэг удаа гаргадаг үзүүлэлтэд Орос улс төсвийн ил тод, нээлттэй байдлаараа 11 байр урагшилжээ. Тус жагсаалтыг Шинэ Зеланд тэргүүлсэн бол Өмнөд Африк удаалжээ. Төсвийн ил тод байдлыг 100 оноогоор үнэлдэг уг жагсаалтад манай хойд хөрш 74 оноо авч аравдугаар байрт оржээ. Дэлхийн эдийн засгийн чуулганд оролцогсод тус улсын удирдлагуудад дээрхи үйл явдалтай холбогдуулан эдийн засгийн тогтвортой өсөлтөө хангахын тулд нийгэм дэх эмх замбараагүй байдлаас сэргийлэх тодорхой бодлогын өөрчлөлтүүд хийх хэрэгтэйг анхааруулжээ.

Энэтхэг

Энэтхэг улсын Сангийн сайд П.Чидамбарам ирэх гуравдугаар сараар дуусгавар болох тус улсын төсвийн гүйцэтгэлээр эдийн засаг нь 5.7 хувиас дээшгүй өсөлттэй гарна гэдгийг мэдэгдлээ. Гэсэн ч энэ жил болон ирэх онд Энэтхэгийн Засгийн газар төсвөө танаж, өсөлтөө хамгаалах бодлого барина хэмээн тэрбээр мөн онцолжээ. Тус улс ирэх оны төсвөө ирэх дөрөвдүгээр сард батална.

À.À Ì ÀÐÑÀÉÕÀÍ Û ÁÓËÀÍ



ОНЦЛОХ

БИЗНЕС ЯМАР БАЙНА ВЭ

И.ОТГОН

Манай шинэ булангийн салхийг хагалсан захирлуудын ярилцлага бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчдад нэгийг хэлж, хоёрыг бодуулах буй за.

Ийм асуултыг бизнесмэнүүдээс сонирхохоор “За яах вэ дээ л. Бизнесийн орчин сайн биш байна. Дотоод, гадаадын бизнес эрхлэгчид, гаднын хөрөнгө оруулагчдад хамгийн чухал нь хууль эрх зүйн орчин тогтвортой, тодорхой байх. Энэ манайд ямар байгааг ерөнхийдөө өөрөө мэдэж байгаа биз дээ. УИХ-ын “үйлдвэрлэж” буй олон хууль бизнесийн үйл ажиллагаатай холбогдохгүй байна гэж бараг байхгүй. Тэгсэн хэрнээ хувийн хэвшлээс санаа оноо сонсож, асууж зөвлөлдөж гаргаж байгаа хууль нэг ч алга ” хэмээн гомдонгуй үгээр ам таглах жишээтэй. Тэд ингэж гомрохоо нь аргагүй ээ. 2011 оныг Бизнесийн шинэтгэлийн жил хэмээн зарлаж байснаас хойш энэ салбарынханд хандсан тодорхой дорвитой арга хэмжээ төр, засгийн зүгээс аваагүй. Мэдээж татварын бодлого, хүнд суртал, авлигыг бууруулах чиглэлээр гаргаж байгаа төрийн бодлого бий л дээ. Гэхдээ хувийн хэвшлийнхний хувьд бизнесийг хөгжүүлэхийн тулд зөвхөн төр, засаг л юм хийх ёстой, биднийг элгэндээ нааж, энгэртээ тэврэх учиртай гэж дутуу дулмаг сэтгэх хүмүүс биш. Тэд, баялаг бүтээгчид учраас хамтдаа хөгжлийн төлөө зүтгэж, үр дүн гаргах ёстой гэдгийг ухамсарладаг. Харин тэдний баялаг бүтээж, ажлын байр бий болгож, иргэдийн амьдралын чанарыг өөд татах гэсэн хичээнгүй, хөдөлмөрч занд эд баялаг, мөнгө төгрөг биш ил тод, нээлттэй засаглал, шударга хууль, дүрэм ус агаар мэт хэрэгтэй.

Эдийн засгийн хурдацтай хөгжил, уул уурхайн их бүтээн байгуулалттай холбоотойгоор сүүлийн жилүүдэд Монголд бизнес цэцэглэж байна хэмээн олзуурхах нэг хэсэг байхад хөгжихгүй байна гэх нөгөө хэсэг бас бий. Ямартай ч энэ талаар сүүлийн жилүүдийн статистик сонирхох аваас хувийн хэвшлийн 40 мянган аж ахуйн нэгж ДНБ-ий 80 хувийг нуруундаа үүрч, 800 гаруй мянган хүнийг ажлын байраар хангаж байгаа аж. Энэ нь 20 гаруйхан жилийн дотор Монголд бизнесийн салбар чамлахааргүй түвшинд хөгжсөнийг илтгэх. Өдгөө уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор Монголд дэлхийн таван тивийн нэр хүндтэй том компаниудаас үйл ажиллагаа явуулж буй. Олон монгол хүн тэдгээр компаниудад ажиллаж оюуны хөрөнгө оруулалт, технологийн ноу хау эзэмшин ажиллаж байгаа нь бизнесийн хөгжилд тустай хэрэг.

Дэлхийн банкны “Doing Business-2013” судалгаагаар манай улс өмнөх жилээс 12 шатаар ахиж 75 дугаар байрт орсон сайн мэдээ бий. Гэсэн хэдий ч бизнес эрхлэгчид авлига, хүнд суртал, зээлийн хүүгийн дарамтад байсан хэвээр. Уг нь бол бизнес хөгжсөн 20 жилийн хугацаанд Монголын банкны салбар хамгийн сайн торнисон ч өрсөлдөх чадвар султай байгааг бизнес эрхлэгчид шүүмжилдэг. Иргэд ч зээлийн хүү хэт өндөр байна гэж байнга гомдоллодог. Уг нь бол арилжааны банкуудын нийт зээлийн хэмжээ өнгөрсөн оны эцсийн байдлаар 7.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар өсчээ. Гэтэл мөн оны дөрөвдүгээр сараас зээлийн хүү өсөж, оны төгсгөлд 18.2 нэгж хувиар нэмэгдсэн байх жишээтэй. Түүнчлэн Төвбанкны явуулсан Зээлийн хүүний судалгаанд хамрагдсан арилжааны банкуудын гүйцэтгэх удирдлагуудын 79 хувь нь зээлийн хүү өндөр гэдэгтэй санал нэгджээ. Тэд санхүүжилтийн эх үүсвэр өртөг өндөртэй байгаа нь хүү буурахгүй байх шалтгаан гэдгээ ч хэлдэг. Банкууд өрсөлдөх чадвараа сайжруулахад анхаарахгүй бол бизнес хөгжихөд бэрх. Учир нь, Монголын банкуудын зээлийн хүү өндөр, нэг банкнаас авах зээлийн хэмжээ хязгаартай, урт биш хугацаатай гээд хяслантай олон асуудал бизнес эрхлэгчдэд тулгардаг. Тийм учраас том хөдөлж буй компанийн захирлууд гаднаас зээл олохыг чухалчилдаг. Гэтэл зээл гаднаас хүссэнээр амар олдохгүй. Хөрөнгө оруулагчдын хамгийн чухал анхаардаг зүйл нь “Танай улсын хууль эрх зүйн орчин хэр тогтвортой вэ” гэдэг асуудал. Тухайлбал, манай энэ удаагийн сэтгүүлд шинээр эхлүүлсэн “Бизнесмэний дуу хоолой” булангийн салхийг хагалсан зочдын нэг болох “Ньюком” компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан Стратегийн ач холбогдолтой салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль Та нарын бизнест ямар байдлаар нөлөөлсөн бэ? гэсэн бидний асуултад “Бодит жишээ дурдахад манай компани хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхээр



гаднын банкуудаас санхүүжилт босгох гэрээ хэлэлцээр хийж байлаа. Гэтэл тэр үеэр энэ хууль гэнэт мэндэлсэн. Мэдээж гаднын банкууд сонин хэвлэлээс дээрх хуулийн талаар уншиж судлаад “Танайд улс төрийн эрсдэл өндөр юм байна. Тиймээс бид зээлийн хүүгээ нэг хувиар нэмлээ гэсэн.Бид манай бизнест хамаарахгүй хууль гэж тайлбарлаад ойлголцолд хүрээгүй” хэмээн сонирхуулав.

Мөн манай сэтгүүлийн англи хэлний редактор, сэтгүүлч Тэрэнс Эдвардсийн бичсэнээр бол Монголд бизнес хийдэг гадаадынхан болон гадаадын хөрөнгө оруулагчдад ойлгомжгүй, тэдний гайхшралыг төрүүлсэн хууль зөвхөн дээрхээр зогсохгүй, саяхан батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай Татварын мэргэшсэн консалтын гэсэн хуулиудыг хууль судалж, ойлгохдоо гаргууд гадаадынхан гайхан хүлээж авч байгаа аж. Хууль шинэчлэгдэж, өөрчлөгдөж болно. Гагцхүү хуулийн хэрэгжилттэй холбоотой дагалдах дүрэм журам нь гарахгүй хүлээлт үүсгэх, гарсан ч ойлгомжгүй тодорхой биш байгаа нь тэдний бухимдлыг төрүүлж байна.

Монголд Жижиг, дунд үйлдвэрүүдийн бүтээмж олон улсын түвшинтэй харьцуулахад муу, ур чадвартай боловсон хүчин, хүний нөөцийн асуудал зэрэг бизнес эрхлэгчдийн толгойны өвчин болсон зүйл олон. Гэхдээ 20 жилийн хугацаанд чамлахааргүй амжилттай хөгжсөн бизнесийн талбарт мэдлэг чадвартай шинийг эрэлхийлсэн залуу үе гарч ирж байгааг энд тэмдэглэх ёстой. Өөрөөр хэлбэл, ерээд оны эхээр зах зээлд хөл тавьсан хүн бүр шахуу гахай үүрч эхэлж байсан Монголын бизнесийн салбарт шалгуур явагдсаар өдгөө дараагийн шинэ үе нь эхэлж байна гэж ойлгож болно. Тэгэхээр энэ салбарт гэрэлт ирээдүй ойрхон. Тийм ч учраас “Mongolian Economy” сэтгүүл хоёрдугаар сарын эхний дугаартаа эдийн засгийн хөдөлгүүр болсон бизнесийн салбарт гол анхаарлаа хандуулж байна. Бид энэ дугаартаа “Бизнесмэнүүдийн дуу хоолой” гэсэн булан шинээр нээж, анхны зочдоо урилаа. Манай шинэ булангийн салхийг хагалсан захирлуудын ярилцлага бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчдад нэгийг хэлж, хоёрыг бодуулах буй за. Уншигчдад маань ч сонирхолтой ярилцлага болсон учраас бид захирлуудын ярианд сэтгүүлийнхээ зай талбайг хармалсангүй. Мөн “Бизнесмэн бичиж байна”, “Made in Mongolia” зэрэг булангаараа хувийн хэвшлийнхэн болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үг, үйлсийг сонирхуулж байна. Манай сэтгүүлийн дараа дараагийн дугаарт ч бизнесийн салбарынхны уншиж сонирхон, судалж мэдэх олон нийтлэл, сурвалжлага, дотоод, гадаадын амжилттай яваа захирлуудын сонирхолтой ярилцлага, бизнес зөвлөгөө байнга явах болно. Нэг үгээр хэлбэл, “Mongolian Economy” сэтгүүл бизнес эрхлэгчдийн ширээний сэтгүүл байх болно. ■

БИЗНЕСМЭНҮҮДИЙН ДУУ ХООЛОЙ

УЛС ТӨРИЙН САВЛАГААГ БИЗНЕСИЙН ОРЧНООС ХАЛМААР БАЙНА



Тэмдэглэсэн Б.ҮҮРИЙНТУЯА, Б.БАЯРТОГТОХ

"Mongolian Economy" сэтгүүл энэ удаагийн редакцийн уулзалтаараа бизнес эрхлэгч, хувийн хэвшлийнхэн болоод төр, засгийн хооронд гүүр болох үүднээс эл салбарын ололт, амжилт төдийгүй тулгарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг хөндөхийг зорилоо. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийнхний санаа бодлыг төрд хүргэх үүднээс бид "Бизнесмэнүүдийн дуу хоолой" буланг шинээр нээж байна.

Манай шинэ булангийн анхны уулзалтад "МІН" группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан, "Ньюком" группын гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан болон "Алтан Дорнод Монгол" компанийн гүйцэтгэх захирал Б.Болд нар уригдан оролцов.

Бид төрөөс зөв бодлого, тогтвортой орчныг л хүлээдэг, хүсдэг

-Сүүлийн жилүүдэд бизнесийн орчин өмнөх жилүүдийнхээс сайжирсан талаар төрийн түшээд ярих болжээ. Дэлхийн банкны "Doing Business 2013" судалгаагаар Монгол Улс өмнөх жилээс 12 шатаар ахиж 75-р байрт орсон бөгөөд бизнес эрхлэх орчин чанаржиж, улмаар энэ салбарт таатай боломжууд бий болсон гэж тодорхойлсон. Тэгвэл дээрх дүгнэлт бодит байдалтай хэр нийцэж байгаа эсэх талаар ярилцлагаа эхлүүлэх үү?

-Д.Жаргалсайхан: Ийм төрлийн судалгаа цөөнгүй байгааг харсан. Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, түүний үр дүнд бизнес, хөрөнгө оруулалтын орчинд хэр хэмжээний өөрчлөлт гарсан тухай дүгнэхэд арай эрт байх. Олон улсын байгууллагуудын судалгаагаар Монгол Улс шат ахиж буй нь сайн. Гэвч бодит байдал дээр Монголд өнгөрсөн жилийн бизнес эрхлэх орчин өмнөх жилүүдийнхээс сайжирсан уу гэвэл үгүй гэж хэлнэ. Бизнесийн орчин 12 шатаар урагшилсан, ахиснаар асуудалд хандаж болохгүй л дээ. Бизнесийн орчин сайжрах асуудал нь зөвхөн төрийн үүрэг



Фотог Э.Зоригт

Зүүн гар талаас Д.Жаргалсайхан, Б.Бямбасайхан, Б.Болд

биш, бизнес эрхлэгчид ч мөн оролцож хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрэх юм. Бизнес эрхлэлт сайжирсан эсэх нь эдийн засгийн болон ажлын байрны өсөлт, иргэдийн амьжиргааны түвшин хэрхэн чанаржсанаар илэрхийлэгдэнэ.

-Б.Бямбасайхан: Өнөөдөр Монголын эдийн засаг хамгийн хурдтай өсөж буй эдийн засгуудын нэг. Ийм нөхцөлд бизнесийн орчин сайжрахаас аргагүй. Учир нь ажлын байр нэмэгдэх, иргэдийн амьжиргааны түвшин ахих зэрэг нь эдийн засгийн өсөлтөө хадгалах гол үндэс юм. Эдийн засаг болоод ДНБ-ий хэдэн хувийг хувийн хэвшлийнхэн бий болгож байгаагаар тус салбарын орчин

сайжирч буй эсэх нь харагдах болов уу.

-Б.Болд: Сүүлийн 20 жилд монголчуудын амьдрал сайжраагүй, бүтээн байгуулалт хийгээгүй гэх яриаг баримттайгаар ярилцаж няцаах нь зүйтэй. Учир нь сүүлийн 20 жилд хийсэн бүтээн байгуулалтаа сайн талаас нь харахад бидэнд хийж, бүтээсэн зүйл цөөнгүй байна. Тухайлбал, маш олон орон сууц, гүүр, авто замтай боллоо. Улаанбаатарын төв замд түгжрэл үүсэхүйц олон тооны машин явж байна. Энэ мэтээр сайн талаас нь хараад нэг дүгнэчих хэрэгтэй. За тэгээд эдийн засаг үргэлж ийм тансаг байсангүй. Ганц “Эрдэнэт”-ийн уулын баяжуулах үйлдвэрээр тэжээгддэг байсан эдийн засаг сүүлийн гурван жил Оюутолгойн хөрөнгө оруулалтаар өнөөгийн хэмжээнд хүрлээ. Оюутолгой төслөөс улбаатай их хэмжээний хөрөнгө, импортын, НӨАТ, гаалийн татвар зэргээр дамжин Монголын эдийн засаг санхүүжиж байна.

Оюутолгойн бүтээн байгуулалттай холбоотой худалдан авалт, ханган нийлүүлэгч, бизнес эрхлэгчдэд өргөн боломж бүрдүүлж өгсөн. Гадаадын томоохон байгууллага, корпорациуд төлөөлөгчийн газруудаа нээж байна. Энэ нь монголчуудаар зөвхөн нарийн бичгийн үүрэг гүйцэтгүүлэхээс илүү Монголд мэдлэгийн ноу-хау нэвтрүүлэх үйл явц явагдаж байна. Хөрөнгө оруулалтын орчин одоогийнхоос илүүтэй сайжирч, улмаар энэ урсгал бүү зогсоосой, тогтвортой байгаасай гэж бодож байна.

Харин улс төрийн савлагааг бизнесийн орчноос халмаар байна. Ингэснээр тогтвортой байдал бий болно.

Ойлголтын зөрүү их байгаа нь хөгжлийн чөдөр тушаа болж байна

-Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль өнгөрсөн тавдугаар сард гарсан. Энэ хуулийг бизнесийн орчныг сайжруулахаасаа илүүтэй боогдуулсан гэж ярих нь их байгаа. Тухайлбал, та бүхний бизнест уг хууль ямар байдлаар нөлөөлсөн бэ?

-Д.Жаргалсайхан: Төр, засгийн зарим төлөөлөгч уг хуулийг гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаагүй гэж үзсэн. Миний бодлоор энэ хуулийг аль ч талаас нь харсан хязгаарласан гэж хэлнэ. Стратегийн гэгдэж буй салбаруудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татахад тодорхой нөхцөлүүдийг заасан. Тэдгээрийг харахад хязгаарласан гэж хэлж болно. Үүний эсрэг тайлбар өгөх олон өнцөг байж болох. Гэвч үндсэндээ уг хууль нь ухралт болсон гэдгийг хэд хэдэн нотолгоогоор баримтжуулж болно. Тухайлбал, Монголд үйл ажиллагаа явуулдаг, гадаадын зах зээлд хувьцаа нь борлуулагддаг компаниудын хувьцааны үнийг харвал хууль гарснаас хойш өмнө нь байгаагүйгээр буурсан үзүүлэлттэй гарсан. Энэ нь юуг илэрхийлж байна вэ гэхээр гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл шууд унасан гэсэн үг. Тухайлбал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг хайгуулын жижиг компаниудын хувьцааны үнэ унаад ирэхээр тэд 2013 онд шаардлагатай хөрөнгө мөнгөө босгож чадахгүйд хүрч байна. 80 центийн үнэтэй хувьцааны үнэ найман цент болсон байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, дээрх хууль хэвийн явж байсан бизнесийн үйл ажиллагаанд саад тотгор болохуйц гэнэтийн шийдвэр болсон. Цаашдаа хөрөнгө оруулагчдыг үргээсэн, бизнест халтай ийм гэнэтийн шийдвэрүүдийг давтахгүйн тулд эрх баригчид, бизнес эрхлэгчид хоорондоо сайн ярилцаж, биенээ сонсож, ойлголцох гүүрийг хуулиар бий болгох шаардлагатай байна. Нэг өглөө сэрэхэд шинэ татвар, шинэ хуультай болчихсон байх нь энүүхэнд. Болд захирлын хэлснээр улс төрийн иймэрхүү савлагаа хөрөнгө оруулалтыг сэгсэрч байна.

-Б.Бямбасайхан: Бодит жишээ дурдахад манай компани хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхээр гаднын банкуудаас санхүүжилт босгох гэрээ хэлэлцээр хийж байлаа. Гэтэл тэр үеэр энэ хууль мэндэлсэн. Мэдээж гаднын банкууд сонин хэвлэлээс дээрх хуулийн талаар уншиж судлаад “Танайд улс төрийн эрсдэл өндөр юм байна. Тиймээс бид зээлийн хүүгээ нэг хувиар нэмлээ” гэсэн. Бид манай бизнест хамаарахгүй хууль гэж тайлбарлаад ойлголцолд хүрээгүй. Хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэх дүрэм, журмыг батална гэж байсан ч өнөөдрийг хүртэл нэгдсэн ойлголтод хүрээгүйн улмаас гарсан тодорхой шийдвэр алга. Яагаад гаднаас зээл босгох гээд зүтгээд байна гэхээр зээлийн хүү бага.

Дотоодын банкуудаас зээл авах нь нэгдүгээрт, нэг банкнаас авах зээлийн хэмжээ хязгаарлагдмал. Урт хугацаатай зээл олдохгүй. Хоёрдугаарт, өндөр хүүтэй зээлээр бизнес эхлүүлэх нь ашиггүй. Зээлийн хүү хэчнээн хувиар нэмэгдэнэ тэр хэмжээгээр бидний хэрэглэгчдэд хүргэх бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өснө шүү дээ. Тэгэхээр эдийн засагт бий болсон тодорхой бус байдал, ойлголтын зөрүү зэргээс хамааран санхүүжилтийн өртөг өндөр болж байна. Манай улсад ойлголтын зөрүү их байгаа нь хөгжлийн нэг чөдөр тушаа болоод байна. Гурван монгол хүн суугаад тухайн асуудлыг ярихаараа гурван өөрөөр ойлгоод гардаг. Ялангуяа ойлголтын зөрүү төр, засагтай харилцах талд илүү илэрдэг.

-Б.Болд: Ийм төрлийн хууль яагаад гарах болсныг хайгаад үзвэл үндсэн хоёр зүйл байна. Нэгдүгээрт, өнөөдөр нийгэмд бизнес эрхлэгчдийг хүндлэхээ байж. Олигарх, тэрбумтан, авлигачин гэх мэтээр нүд үзүүрлэн ярьдаг. Хоёрдугаарт, гаднынхан манай баялгийг авах нь гэсэн хардлага сэрдлэг нийгэмд бүгжээ. Нийгмийн ийм сэтгэлгээ биднийг хаашаа хөтлөх вэ гэвэл эцсийн цэг нь Африк байх болно. Ардчилсан Конго гэдэг улсын байдал руу яваад байна гэдгээ ойлгож, айх хэрэгтэй байна. Хувь хүний эд хөрөнгө, өмчлөл, гадаадын хөрөнгө оруулагчдыг хязгаарлах асуудал үндсэндээ эдийн засгийн бүтцийн буруу зохион байгуулалтаас болж байгаа юм. Оюутолгой, Тавантолгой Монгол Улсыг тэжээнэ. Би Монгол Улсын иргэн. Тиймээс хувь хүртээд хөдөлмөр эрхлэлгүй сайхан амьдрах боломжтой гэх сэтгэлгээ иргэдийн дунд бий болж.



Энэ буруу жишиг, мөрөөдөл их аюултай. Харин улстөрчид энэ сэтгэлгээнд “дөрөөлж”, би төрийн эрхэнд гараад бизнесмэнүүдээс татвар ахиу хурааж, их хэмжээний мөнгийг улсад хуримтлуулснаар иргэд хувь хишиг хүртэх боломжтой гэж амладаг. Нийгмийн баялгийг бүх иргэнд хүртээнэ гэж ярьж амлаж гарч ирдэг. Татвар төлөгч бол бизнесмэн. Сонгогч иргэн хоёрын бие махбодь өнөөдөр манайд салчихсан явна. Ардчилсан нийгмийн тогтолцоотой улс орнуудыг харвал татвар төлөгч, сонгогч хоёр нэг хүн байдаг. Би татвараа төлдөг, төр миний төлөө ажиллах ёстой. Нийгмийн шударга байдлын төлөө бодлогоо чиглүүлэх учиртай.Тэгэхээр төрийн дээд албанд гарч ирээд бизнесээс татвар хурааж аваад иргэдэд тараана гэх энэ сэтгэлгээг халах хэрэгтэй.

-Яаж халах вэ?

-Яаж халах арга замын тухайд Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байсны хувьд нэг зүйлийг хэлмээр байна. Нийтийн өмчийн компани гэдэг нь төрийн өмчийн компани биш. Энэ бол хувьцаат компани. Дэлхийн томоохон компаниудыг жагсаагаад үзвэл 95 хувь нь нэг гэр бүлийнх эсвэл олон нийтийн компани байдаг. Төрийнх биш. Тухайлбал, ОХУ-ын “Роснефть”, “Газпром”, “BHP”, “Рио Тинто” гэвд дурдаж болно. Эдгээр компанийн хувьцааны 20-30 хувь нь ямар нэг хөрөнгийн бирж дээр худалдаалагдаж байдаг. Учир нь тухайн улсын баялгийг нийтэд хүртээх нэг хэлбэр юм. Үүгээр дамжуулан олон улсын байгууллага, хөрөнгө оруулалтын мэргэжлийн сангууд шаардлагаа хүргүүлнэ, тухайн компаниас, удирдлагаас олон зүйлийг шаардана. Ард иргэдэд хувьцааны үнийн хэлбэлзэл мэдрэгдэж эхэлнэ, нөлөөлнө. Жишээ нь, би тухайн компанийн хувьцаанд 500.000 төгрөг оруулсан байтал төр, засгийн савлагаатай бодлогоос улбаалаад миний хувьцааны үнэ 100.000 төгрөг болтлоо унана. Би улстөрчид рүү хандаж тогтвортой бодлого явуулахыг шахаж шаардана биз дээ. Татвар төлөгч, сонгогч хоёр ингэж нэг ашиг сонирхолтой болж байгаа юм. Тэгэхээр Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах тухай хуулийг яагаад гаргаж ирэх болсон шалтгааныг сайтар судлах ёстой болов уу. Асуудлыг өнгөц биш, уг руу нь орж ярих хэрэгтэй байна. Монголд орж ирж буй гадаадын компаниудад төрөөс хяналт, шалгуур тавих үүднээс ийм хууль гаргасан байх. Дагалдах дүрэм журмаа хурдан гаргамаар байна.

-Төр, засаг хувийн хэвшлийнхнийг дорвитой бодлогоор дэмжихгүй юм бол дуугүй байвал том дэмжлэг болно гэдэг. Харин манай төр хувийн хэвшилд хэт оролцоотой байна. Төрийн өмчит компаниудын тоог аль болох цөөлөх байтал нэмэх боллоо. Ер нь төрийн, төрийн албан хаагчдын бизнесийг эрхшээлдээ байлгах хүсэл хэзээ арилах бол?

Б.Болд: -Төр хувийн хэвшилд хэт хутгалдаж, боогдуулж байна гэдэгтэй би хувьдаа санал нийлэхгүй байна. Харин нийгмийн өмчийг түр гарсан улс төрийн томилгоогоор захиран зарцуулах эрхийн энэ хэлбэрийг хязгаарламаар байна. Мэргэжлийн менежментийн багт төрийн болон олон нийтийн компанийн удирдлагыг шилжүүлэх хэрэгтэй. Улстөрч, компанийн захирал хийдэг, эсвэл тэр фракцийн хүнийг удирдлагаар томилохын оронд нээлттэй уралдаан зарлаж, өрсөлдөөнийг бий болгох шаардлагатай. Манайд өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй, мэдлэг чадалтай залуус гарч ирж байна. Тэдэнд өрсөлдөөний талбар хэрэгтэй. Өнөөдөр төрийн өмчийн компанийг иргэдийнх бус тухайн улс төрийн бүлэглэл, хоорондын тохиролцоон дээр үндэслэсэн хэтэвч хуваах нэгэн хэлбэр гэж хэлж болох. Тэгэхээр “шахааны” бизнесийг үгүй хийх бас нэг арга бол менежментийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох, хөрөнгийн бирж дээр 10-20 хувийг гаргах, төрийн савлагаатай өнөө үед энэ олон нийтийн гэвд байгаа

компаниудын өмчлөлийн удирдлагыг салгах шаардлагатай. Өмчлөлийн хувьд томоохон объектуудыг төр, хувийн хэвшил, олон нийт хосолсон хэлбэрт шилжүүлэх нь оновчтой арга байж болох. Тухайлбал, эрчим хүчний том компаниудыг төр, олон нийт, хувийн өмчлөлийн хэлбэр рүү шилжүүлбэл яасан юм бэ. “Эрдэнэт” үйлдвэр, УБТЗ, МИАТ-ийн тендерүүд Оюутолгой шиг сонин хэвлэлээр байнга явж харагддаггүй шүү дээ. Ийм байдлаар асуудлыг эмх цэгцэнд оруулмаар байна.

Б.Бямбасайхан: -Бид Засгийн газраас зөв бодлого, тогтвортой орчныг бүрдүүлэхийг л хүлээдэг, хүсдэг. Үүнд үндэслэн хувийн хэвшлийнхэн төслүүдээ боловсруулж, хөрөнгө босгох, улмаар хэрэгжүүлж эхэлнэ. Ингэснээр ажлын байр бий болохоос Засгийн газар тэдгээрийг бий болгохгүй. Учир нь Засгийн газрын гол үүрэг бол хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын орчныг тодорхой байлгах ёстой. Монголын эдийн засаг өсөж байна. Энэ нь боломж байна гэсэн үг. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар дэвшилт технологи, менежментийг нэвтрүүлж, хэрэглэгчиддээ тохирсон үйлчилгээг нутагшуулна. Энэ зарчмыг чандлан баримтлах хэрэгтэй. Ажлын байр бий болгож байна гээд менежментийн асуудалд оролцоод байвал сөрөг үр дагавар нь их байх магадлалтай. Тэгэхээр Засгийн газар хүлээсэн үүргээ биелүүлээд бусдыг нь чөлөөлөх юм бол үр ашигтай, сайн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болно.



Д.Жаргалсайхан: -М.Энхсайханы Засгийн газрын үед төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цэгцлэх талаар дорвитой арга хэмжээ авч байсан. Тухайлбал, тухайн үед яамдууд бодлогоо боловсруулдаг, хэрэгжүүлэгч агентлаг, хянадаг бүтэцтэй байлаа. Эцэстээ олон Засгийн газрын нүүр үзсээр яам гэдэг байгууллага өнөөдөр 1996 оноос өмнө ямар байсан тэр тогтолцоондоо эргээд очлоо. Өөрөөр хэлбэл, яамдууд өнөөдөр боловсруулсан бодлогоо хэрэгжүүлж, зөвшөөрөл өгч, үр дүнг нь хянах болж байна. Энэ чинь ёстой нөгөө ариун явдал мөн үү гэдэг шиг л юм болж байна шүү дээ. /инээлдэв/ Ийм тогтолцоо нэг ёсондоо ухралт болж байна. Төрийн өмчийн компаниуд дээр Шинэ Зеландын туршлага буюу ТУЗ-ийг нэвтрүүлэхээр баг томилогдож байсан. ТУЗ-ийг тодорхой хугацаанд ямар ч улс төрийн хүчний үед тогтвортой ажиллах жишиг нэвтрүүлэхээр ажиллаж байсан.

Харин одоо бид амжилтаасаа ухарч байгаа нь харамсалтай. Нөгөө талаар нөхцөл байдал бүхэлдээ бараан биш, гэрэл гэгээтэй зүйл бий. Гагцхүү бид санаа амрах болоогүй. Улс төрийн тогтворгүй байдал хувийн хэвшлийн гэлтгүй бусад салбарт ч чөдөр болж буй. Нийтэд таалагдах гэсэн улстөрчдийн хүслээс энэхүү тогтворгүй байдал үүсэж байгаа юм. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэг үг байдаг. Төрөөс зарим хууль дүрмийг олон нийтээр хэлэлцүүлж баймаар байна. Тэгээд гаргасан хууль, дүрмийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулбал гарч болзошгүй сөрөг үр дагавраас сэргийлж болно.

Шинийг эрэлхийлсэн шинэ үе бий болж байна

-Төр, бизнес эрхлэгчид хоорондын эргэх холбоо муу, хувийн хэвшлийнхний дуу хоолой төрийн түшээдэд хүрэхгүй байгаа тухай ярьдаг. Монголын компаниудын хөгжлийн түвшин өнөөдөр ямар байна вэ. Манай компаниуд олон улсын стандартын

түвшинд очиж ажиллах хугацаа хэр хол байгаа бол?

Б.Бямбасайхан: -Нэн тэргүүнд өрсөлдөх чадвар дутагдалтай салбараа тодорхойлмоор байна. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр судалгаа хийдэг. 14 улстай харьцуулж гаргадаг судалгаанаас харахад манай тодорхой салбаруудад өрсөлдөх чадвар харьцангуй сайн байгаа.Тухайлбал харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын хөгжил хурдацтай хөгжиж байна. Хөрөнгө оруулалтын үр дүн хүмүүсийн нүднээ ил байна шүү дээ. Монголчууд дэлхийн хүмүүсийн хэрэглэж буй утас, тоног төхөөрөмжийг хэрэглэж байна. Амжилттай яваагийн үндэс нь зөв бодлого. Тухайн салбарыг чөлөөлж өгснөөр өрсөлдөөн бий болсон. Тэгвэл иргэний агаарын тээвэр, эрчим хүчний салбарын өрсөлдөх чадвараар нөгөө 14 улстай харьцуулахаар Монгол Улс байнгын 15 дугаар байрт бичигддэг.

Дэд бүтцийн салбар нь Монголын хэрэглэгчид хэр өндөр үнэтэй зүйл хэрэглэж байгааг тодорхойлдог. Энэ салбарт дутагдал байна гэдэг нь бизнесийн хувьд боломж. Учир нь дэд бүтцэд санхүүжилт хэрэгтэй, том төслүүд хэрэгжиж, зам, эрчим хүчний шугам зэрэг том бүтээн байгуулалт явагдана. Үүгээр дамжуулаад ажлын байр бий болно. Нөгөө талдаа хүний асуудал. Дэлхийн эдийн засаг, зах зээлийн өөрчлөлт Монголд хамааралтай болж байна. Харин Монголд байдал хэрхэн өөрчлөгдөж буй нь гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах болсон. Болд захирлын ярьснаар манайд мэдлэг чадвартай, шинийг эрэлхийлсэн шинэ үе бий болж байна. 20 жил бизнесийн салбар хурдацтай хөгжлөө. Одоо дараагийн хөгжлийн үе эхэлж байна. Харин тэдгээр шинэ үеийн залуус мэдлэг чадвараа бизнесийн зөв менежмэнт хийхэд зориулах хэрэгтэй. Сурсан мэдсэнээ Монголын бизнесийн хөгжилд зориулснаар улс орон тэр хэрээр хөгжиж, бизнесийн зөв хөгжил улам хурдсах болно гэж бодож байна. Мэргэжлийн хүний нөөц, хариуцлагатай байх шаардлага гарна. Өөрөөр хэлбэл, амархан аргаар мөнгө олох, улс төрийн амбиц хөөхийн оронд бизнесийн салбарт өрсөлдөөнийг идэвхжүүлэхийн тулд Монголын шинэ үеийн залуус мэдлэг, чадвараа бүрэн дайчлах хэрэгтэй.

Б.Болд: -Онолоос үзвэл эдийн засгийн хөгжлийг бүрдүүлэх хоёр үндсэн зүйл байна. Нэгдүгээрт, хөдөлмөрийн бүтээмж. Бизнесийн салбар бол амьд байгууллага. 50, эсвэл 500 ажилтантай байхаас үл хамааран нэг асуудал бий. Хүний хөдөлмөрийн бүтээмжийг яаж үнэлэх юм, тэр бүтээмжид тохирсон цалин хөлсийг яаж өгөх юм гэдгийг тодорхойлох ёстой. Бүтээмжийг өнөөдөр үнэлэх гэхээр дэндүү хий хоосон олон юманд цаг үрэх болдог. Өрсөлдөөнийг бий болгож, хөдөлмөрийн бүтээмжийг үнэлэхийн тулд цаг дэмий үрж болохгүй. Өнөөдөр манай зарим компани гүйцэтгэх захирал, удирдлагыг гэрээгээр ажиллуулдаг. Гэрээндээ тодорхой заалтуудыг зааж өгөөд, оны эцэст заалтуудаараа ажлын үнэлгээг тооцож, цалин дээр нь урамшуулал олгох маягаар ажилладаг. Үүнийг MCS, “Ньюком” зэрэг дотоодын томоохон компаниуд хэрэгжүүлээд, тэргүүлээд явж байна. Мөн барууны компанийн том засаглалтай, системтэй компаниуд орж ирж, манай гайгүй залуусыг татан авч ажиллуулж байгаа нь Монголын хувийн хэвшлийн хөгжилд тустай зүйл юм. Нөгөө талаас хувийн жижиг компаниуд дөнгөж суралцаж эхэлж байгаа. Соёлын шилжилт явагдаж буй хэрэг. Тухайлбал, гадаад, дотоодод сурсан, шинэ, хуучны тогтолцоо, шилжилт хөдөлгөөн, хотжилт гэсэн ийм үед Монголын бизнесийн орчин байнгын өрсөлдөөн, динамик хөдөлгөөнд оршиж байна. Үүнийгээ улам сайжруулахын тулд бүтээмж, түүнийг тодорхойлж, улмаар үнэлэх тогтолцоог нутагшуулах нь зүйтэй.

Хоёрдугаарт, капитал хуримтлал. Манайд хуримтлал гэдэг зүйл үүсэхгүй, өдөр тутмын зардал болж байна. Тухайлбал, дэд бүтэц, эрчим хүч, уул уурхайн салбар их хэмжээний капитал, хөрөнгө оруулалт шаарддаг. Асар урт хугацааны дараа хөрөнгө оруулалтаа нөхдөг салбарууд. Гэтэл эдгээр салбарын компаниудыг арай гэж хөл дээрээ зогсож байтал Засгийн газар солигдоод шинээр гарч ирсэн нөхөр бүтээсэн, хийсэн ажлыг нь нураах явдал гарч байна. Ийм тогтворгүй байдал тухайн салбарыг уналтад хүргэдэг. Бизнесийн ашиг дивиденд буюу ногдол ашгаар явдаггүй, харин капитал хөрөнгө оруулалт, тайлан тэнцэл, цэвэр ашгаар юу хийсэн бэ гэдгээр гардаг. Тухайн байгууллага цэвэр ашгаа хөрөнгө оруулалт хэлбэрээр зарцуулаад, ажлын байр нэмсэн бол төрөөс татварын хөнгөлөлт эдлүүлэх бодлого хэрэгжүүлж болох юм. Энэ монгол бизнесмэн баяжаад ирлээ, одоо унагана гэсэн тамын тогооны үлгэр ярихын оронд боломжийг бүрдүүлж, улмаар өрсөлдөөнийг дэмжих учиртай. Аливааг зөв талаас нь харъя. Нөгөө талаар монголчууд бие биенээ хайрламаар байна. Гаднын нөхрийг хараад бөхөлзөж гүйгээд, дотоодын хөрөнгө оруулагчийг болохоор хялалздаг байдлыг өөрчилмөөр. Гаднын хүн нэгэн цагт гараад л явна. Дотоодын бизнесмэнүүд хөөрхий барилгаа бариад, баялаг бүтээх гээд л эх орондоо ажиллаад үлдэнэ. Цөөхүүлээ шүү дээ, бид.

Б.Бямбасайхан: -Бизнес ашигтай байж бизнес болдог. Ашигтай, тогтвортой байхын тулд хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ хөдөлмөрийн бүтээмжийг үнэлдэг байх нь чухал.

Д.Жаргалсайхан: -Монгол нээлттэй эдийн засагтай болсноор дэлхийн эдийн засгийн нэг хэсэг боллоо. Тэгэхээр Монголд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийнхэн дампуурахгүй, амжилттай явахын тулд өөрсдийгөө хөгжүүлж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэхээс өөр сонголт үгүй. Ингэж чадахгүй нөхцөлд зах зээлээс арчигдана. Манай олон компани иргэдийн хараа хяналтаас гарч, алга болоод байгаа нь нууц биш. Тэд өрсөлдөх чадвараа сайжруулахын төлөө юу ч хийгээгүйтэй холбоотой юм. Зарим компани буруу аргаар ажиллахыг хичээж байна. Энэ бол богино хугацааны л асуудал байх. Цаашдаа урт хугацаанд амжилттай бизнес эрхлэхийн тулд олон улсын жишигт нийцэхүйц үйл ажиллагаа явуулахын төлөө ажиллах хэрэгтэй. Ийм ч шаардлага тулгарна. Манай олон компани энэ чиглэлээр эхлэлийг зөв тавиад явж буйг хүмүүс тэртээ тэргүй ялгаж салгаад харж байгаа.

-УИХ-ын гишүүн С. Дэмбэрэл нэгэн ярилцлагадаа 2013 онд бодит секторт эдийн засгийн идэвхжлийг сайжруулахын тулд мөнгөний бодлогын нийлүүлэлтэд өөрчлөлт оруулаа. Харин зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулж чадаагүй нь гол дутагдал хэмээсэн байна. Та бүхний хувьд Монголын банкуудын зээлийн нөхцөл, харилцааг хэрхэн дүгнэх вэ. Ямар шинэчлэл хийгээсэй гэж хүсэж байна вэ?

Д.Жаргалсайхан: -УИХ-д Үнэт цаасны тухай хуулийг цогцоор нь шинэчлэх хуулийн төсөл өргөн барьсан байна лээ. Бизнес эрхлэгчийн хувьд үүнд том ач холбогдол өгч байгаа. Энэ хуулийн төслийг богино хугацаанд хэлэлцэн шийдвэрлэж, хүчин төгөлдөр хууль, эрх зүйн акт боловсруулаасай гэж хүсэж байна. Монголын банкны салбарыг өнөөдөр хүнтэй зүйрлэвэл өрөөсөн хөлтэй байгаа юм. Төвбанк тэдийгүй судлаач, мэргэжилтнүүд ч үүнийг хүлээн зөвшөөрдөг. Бид банкууд хоорондоо өрсөлдөж, улмаар хүү буурна гэх горьдлого тээгээд 20-иод жилийг үр дүнгүй үдлээ. Банкууд бидний мөнгийг авахын тулд өндөр хүү амладаг. Ингэснээр бидэнд эргээд зээл олгохдоо бага хүүтэй өгөх боломжгүй. Харин дээрх хууль батлагдсанаар банктай өрсөлдөх хэмжээний санхүүгийн үйлчилгээний салбарыг дэмжих, хөгжүүлэх нөхцөл бүрдэх юм. Ингэснээр л банкны зээлийн хүү буурах болно.

Б.Бямбасайхан: -Өрсөлдөөнийг бий болгох нь чухал. Банкны салбар сүүлийн 20-иод жилд хамгийн их “торнисон” салбар гэж хэлж болно. Одоо тодорхой өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай. Өнөөгийн байдлыг харахад хэтэрхий олон арилжааны банк байна гэх дүгнэлтүүд байдаг. Монголын чухал салбарууд дэлхийн тавцанд өрсөлдөх чадвартай байгаа бол банкны салбар ч мөн адил байхын зэрэгцээ энэ салбарт гаднын сайн банкуудыг оруулж ирж, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх боломжийг нээх хэрэгтэй.

Б.Болд: -Банкуудын хувьд хүүгийн түвшинг бууруулахын тулд хадгаламжийн хүүгээ бууруулах ёстой. Өөрөөр хэлбэл, эх үүсвэр татаж буй өртөг буурсан тохиолдолд зээлийн хүү буурна. Гаднын хөгжиж буй орны бэлээхэн жишээ бий. Тухайлбал, сүүлийн үед эдийн засаг нь амжилттай хөгжиж буй орны банкууд олон улсын бондын зах зээлээс бага хүүтэй, урт хугацааны хөрөнгө босгож байх жишээтэй. Казахстаны банкууд гэхэд олон тэрбум ам.долларын бондыг Лондонд гаргалаа. Малайз мөн адил гадаад зах зээлээс бага хүүтэй зээлийг амжилттай босгосон. Хөгжиж буй орнуудын банк нь хамгийн түрүүнд олон улсын зах зээлд бонд гаргаж байна. Манай Худалдаа хөгжлийн банк долоон хувийн хүүтэй бонд гаргасан. Дараа нь Хөгжлийн банк. Оны өмнөхөн Засгийн газар таван хувийн хүүтэй бонд гаргалаа. Үүнийг дагаад “Голомт”, “Хасбанк” бонд гаргах байх л даа. Гаргаж буй бонд нь 6-7 хувийн хүүтэй ороод ирвэл банк дотооддоо есөн хувийн хүүтэй зээл өгөх боломжтой. Өмнө нь олон улсын зах зээлд гарах боломж бидэнд хомс байлаа. Монгол гэж ямар улс байдаг, хаана оршдог юм. Эдийн засаг нь жижиг гээд чамлах, үл тоох хандлага байсан. Монгол Улсыг мэддэггүй хөрөнгө оруулагчид байлаа шүү дээ. Мэдэх нэг нь мориноосоо буугаагүй гэх сонин ойлголттой. Харин сүүлийн 2-3 жилийн хугацаанд Оюутолгой, Тавантолгойн хүчинд олон улсын хөрөнгө оруулагчид бүгд манай улсыг мэддэг болсон.

-Хямд эх үүсвэр олох асуудал арилжааны банкуудын хувьд хамгийн чухал. Тэгэхийн тулд төрийн тогтвортой бодлого чухал уу ?

Б.Болд: -Ирээдүйд эдийн засаг тэлэх тусам банкуудын хэмжээ томорно. Энэ хэрээр олон улсын зах зээлд банкууд гарах гарц нээгдэнэ. Хамгийн хямдхан мөнгөний эх үүсвэр босгохын тулд бондын доод түвшин гэж байдаг. Энэхүү хэмжээ нь 150 сая ам.доллар. Гаргаж буй бондын хэмжээ хамгийн багадаа л энэ хэмжээний байна гэсэн үг. Үүнээс бага байвал өндөр хүүтэй болчихдог. Өдөр тутмын арилжаа хийх учраас хөрвөх чадвартай байлгахын тулд бондын доод түвшинг тогтоож өгдөг. 150 сая ам.доллараас дээш хэмжээний бонд гарвал арилжаа сайжирна. Тиймээс дээрх хэмжээний ам.долларыг гаргахын тулд банк өөрийн гэсэн тодорхой дүрмийн сантай байх учиртай. Энэ нь 100-150 сая ам.доллар. Ийм дүрмийн сантай банк Монголд 3-4 л байна. Ирээдүйд ам.долларын нөлөөгөөр нэгдүгээрт, зээлийн хүү буурахаар харагдаж байна. Хоёрдугаарт, Засгийн газрын босгосон бондын тодорхой хувийг арилжааны банкуудад дамжуулан байршуулж, эдийн засагт хөрөнгө оруулалт хийснээр долларын хүү буурах нөхцөл бүрдэх юм. Гэхдээ төгрөг, ам.доллар хоорондын ханшийн бодлого хаачих вэ гэсэн Монголбанкны том асуудал үүсэж байна. Ер нь ирээдүйд төгрөг чангарах талдаа хэлбийнэ. Ханш тогтвортой байх ёстой. Савлаад байвал арилжааны банкны салбарт ч хүүгийн түвшинг барихад хэцүү болно. Тиймээс хямдхан мөнгөний эх үүсвэр босгохын тулд Монгол Улс эрсдэл багатай болъё. Эрсдэлээ бууруулахын тулд тогтвортой бодлого хэрэгтэй. Уялдаатай байгаа биз. Төрийн бодлого тогтвортой, савлахгүй байх гэдэг үг захирлуудын бараг л яриа бүрт давтагдаж байгааг ойлгох хэрэгтэй.

УИХ хянаж, Засгийн газар мөнгийг нь гаргавал жинхэнэ өр болно

-Чингис бондын асуудал нийгмийг олон хэсэгт хуваажа байна. Засгийн газраас бонд эдийн засгийг хөгжүүлнэ гэж тайлбарлаж байгаа. Харин эдийн засагчид эргэлзээтэй хандаж байна. Тэгвэл эрсдэлийг бодитоор үнэлж, цэгнэдэг хувийн хэвшлийнхний төлөөлөл энэхүү бондын талаар ямар бодолтой байна вэ?

Б.Бямбасайхан: -Эдийн засагт хөрөнгө оруулалт хийх нэг хэлбэр бол бонд. Чингис бонд нь Монгол Улсын нэр хүндээр баталгаажсан эрсдэлтэй өр юм. Үүнийгээ эдийн засагтаа маш зөвөөр шингээх хэрэгтэй. Ялангуяа, дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт байдлаар царцааж, зам харгуйг засаж, цахилгаан, дулааны сүлжээг барина гэвэл зөв. Эрчим хүчний салбарын хүрээнд тогтоод ярьъя л даа. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эрчим хүчний салбарыг хөгжүүлэх бодлого, дүр зурагтай явж ирлээ. Энэхүү зураг



нь эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарт өрсөлдөөнийг бий болгох зорилготой. Өөрөөр хэлбэл, хувийн хөрөнгө оруулалтыг эрчим хүчний салбарт татан оролцуулахад чиглэсэн. Хувийн цахилгаан станцыг бий болгоё. Энэ салбар хэнд ч нээлттэй, орж гарахад чөлөөтэй байг. Зарим нарийн асуудлыг нь стратегийн ач холбогдолтой учраас төр зохицуулаад яваг. Цахилгаан эрчим хүч дамжуулдаг, түгээдэг салбараа өрсөлдөөнтэй болгоё. Өрсөлдөөн орж ирснээр хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хүрнэ. Эдийн засгийн үүднээс харвал эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хэрэгтэй болчихсон. Эдийн засаг өсөхийн хэрээр эрчим хүчний хэрэглээ өсөж байна. Тэгэхээр засаг босгосон мөнгөнөөсөө энэ салбарт санхүүжилт хийж, эрчим хүчний салбарыг хөгжүүлэх гэсэн бодлого зөв юм. Өөрөөр хэлбэл, бонд бол зөв алхам. Харин хариуцлагатай зарцуулах учиртай гэдэг дээр л анхаарах ёстой.

Б.Болд: -Бондын хөрөнгийг хэрхэн үр ашигтай зарцуулах нь маш нарийн сайн зохион байгуулагдах том үйл явц. Засгийн газрыг ийм хэмжээний мөнгө босгосонд талархаж байгаа. Гэтэл энэ мөнгөө өр болгож үлдээх үү, хөрөнгө оруулалт болгох уу. Илүү ачаа болох уу, илүү орлого болгох уу. Үүнийг илүүтэй мэдрэх шийдвэр гаргадаг засаглалын тогтолцоо өнөөдөр хаана байна вэ. Энэ тогтолцоог бүрдүүлэх хүртлээ арилжааны банкуудад итгэл хүлээлгэхэд буруудахгүй. Арилжааны банк итгэл хүлээх туршлагатай болсон гэж бодож байна.

Харин УИХ шийдвэр гаргана гэж яриад байна. Гэтэл хууль тогтоох байгууллага Засгийн газрын ажлыг хийх ёстой юм уу. Засгийн газрын ажлаас даваад доод шатны агентлагийн ажлыг өмнөөс нь хийж өгөх юм уу. Нэг тэрбум ам.долларыг малчинд өгөх үү. Эрчим хүчний салбарт олгох юм уу. Эрчим хүчний салбарт өгөхийн тулд тендер зарлах уу. УИХ тендерийг нь зарлах юм уу. Тиймээс бондын хөрөнгөд хэн хэрхэн, яаж оролцох нь тодорхой байх ёстой. Өөрөөр хэлбэл, америкчуудын ярьдаг тойрог дотор чөтгөр чинь амьдраад байна. Тиймээс хөрөнгө оруулалтынхаа тойрогт ормоор байна. Бонд гаргаад мөнгөө босгочихлоо. Хяналтын ямар бие даасан бүрэлдэхүүн байх юм бэ. Засаглалын хувьд хэрхэн тунгалаг цэвэр авч үлдэх вэ. Нэн тэргүүнд улс орныхоо ашгийг бодох ёстой. Бондын зарцуулалтад хяналт тавьж байдаг есөн хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ байгуулъя. ТУЗ-д нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Олон улсын валютын сангаас өөр ямар төлөөллийг оруулах уу. Магадгүй, нэг сайн хуульч хэрэгтэй. Мэргэшсэн нягтлан бодогчийн холбооноос нэг нягтлан бодогч авъя. Өмгөөлөгчдийн холбооноос нэг хүн тавъя. Ингээд энэ хяналтын багийг улстөрийн шийдвэр гаргалтаас тусгаарлая. Хөрөнгө оруулалтын өгөөжийг нь зөв тооцъё.

Хамгийн муу төлөвлөгөөнд ч манай бондын хүү төлөгдөх чадвартай байх ёстой

Цаасан дээр нь ТЭЗҮ их гоё бууна шүү дээ. Гэтэл амьдрал дээр ийм юм байдаггүй. Асар их хэмжээний эрсдэлтэй байдаг. Төмөр зам гацна. Нефтийн үнэ савлана. Энэ бүх эрсдэлийг бодсон хэд хэдэн төлөвлөгөө байх ёстой. Хамгийн муу төлөвлөгөөнд ч манай бондын хүү төлөгдөх чадвартай байх ёстой. Үүнийг тооцоолно гэхээр маш нарийн процесс болж байгаа биз. Сангийн сайд асан С.Баярцогтын ярьснаар 3000 өгөгдөлтэй загварыг гаргаж ирдэг санхүүч бидэнд хэрэгтэй. Тэр хүмүүсээр нь эхлээд хийлгүүлье. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын шийдвэр, засаглалын шийдвэр гаргалтын тогтолцоо хийсвэр биш байгаасай. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, бондын үр ашигт аудит хийж, хяналтаа сулруулж болохгүй. Иргэний төлөөлөл, байгууллагыг бондын хяналтад заавал оролцуулах

шаардлагатай.

Д.Жаргалсайхан: -Хоёр захирлын ярьсантай 100 хувь санал нийлж байна. Бямбасайхан захирлын хэлсэн дээр нэмж хэлэхэд манайх дэд бүтэц гэж ярьдаг. Энэ бол хуучин, социалист нийгмээс өвлөж авсан буруу нэр томьёо. Манайх нэр томьёогоор дамжаад сэтгэлгээний том зөрчилтэй зүйл рүү ороод байна. Дэд бүтэц гэхээс илүүтэй суурь бүтэц гэж нэрлэх нь оновчтой болов уу. Эрчим хүч, холбоо, эмнэлэг байна. Суурь бүтцэд хөрөнгө оруулалт хийх нь зөв байх. Болд захирлын хэлж байгаа асуудал бол бидний өдөр тутмын амьдралд тохиолдож байдаг том эрсдэл. Маш няхуур үйл ажиллагааг төр, засаг бий болгох ёстой. Хөрөнгөө зарцуулж эхлэхээс өмнө үүнийг бүрдүүлэх хэрэгтэй. Ганцхан жишээ хэлэхэд, манайх жижиг хөрөнгө оруулалтын компаниудтай. Бидэнд ирж буй ТЭЗҮ-д буй тоо, баримт баталгаатай байдаггүй. Дурын нэг тоогоо бичээд ирсэн байх жишээтэй. Үүнийг ТЭЗҮ гэвэл нотлоод байдаг. ТЭЗҮ-ийг боловсруулсан нөхөр нь би салбартаа 20 жил ажилласан. Тоог нь шалгая гэхээр чи надад итгэхгүй байна. Би мэддэг хүн гэдэг ч юм уу. Бодитоор гардаг ТЭЗҮ -д дунджаар 2500 орчим шийдэл гардаг юм билээ. Тиймээс дээрх шийдлийг бүгдийг нь шалгах хэрэгтэй. 2500 нь эрсдэлгүй гэвэл хөрөнгө оруулалтаа хийнэ гэсэн үг. Төсөл бүр чинь өөрийн гэсэн онцлогтой. Өөрөөр хэлбэл, нялх хүүхдийг арчилж байгаатай адилхан. Тиймээс хөлд орж, хоолныхоо захад хүртэл нь хөрөнгө оруулагч дагаж явах ёстой. Түшиж тулдаг байх хэрэгтэй. Харин УИХ хянаж, Засгийн газар мөнгийг нь гаргавал жинхэнэ өр болно.

Б.Бямбасайхан: -Бонд гаргаснаар эдийн засаг өнөөгийн түвшинд хүрээгүй. Өнгөрсөн 20 жилийн үйл явцын дүнд боломжийн хүүтэй бонд босголоо. 20 жилийн дотор бид мөнгөгүй байхдаа сайн салбарын зохицуулалт, ямар зарчмаар явах загвараа хийгээд авсан. Үүнийг маш олон хүний тусламжтайгаар, олон эрдэмтэн судлаач нийлж хийсэн. Сууриа хийсэн юм чинь санхүүжилтийг нь гаргаж ирээд хийх ёстой. Түүнээс бид гэнэт бондтой болоод 20 жил хийсэн зүйлээ мартаад, эргээд 21 жилийн өмнө ямар байсан аргаараа хөрөнгө оруулалт хийвэл буруудна. Харин одоогийн суурь дээрээ үндэслээд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй.

-Монголын уул уурхайн салбар гэхээр Оюутолгой, Тавантолгойгоор төсөөлөх боллоо. Санал нэг байна уу?

Б.Болд: -Оюутолгой, Тавантолгойг ашиглая. Бусад улс даяар байгаа уул уурхайг зогсооё гэвэл тодорхой хугацааны дараа дээрх хоёр ордын нөөц ч дуусна. Уул уурхайг төр эзэмшинэ. Эсвэл гаднын том хөрөнгө оруулагч эзэмшинэ.

Монголд хувийн уул уурхай байж болохгүй гэсэн дүгнэлтэд хүргэх ийм асуудал болж байна. Тийм учраас уул уурхайн салбарыг бид яриад байгаа. Эхнээс нь хайгуул гэж юу юм. Мөнгө нь яаж босдог. Дараа нь үргэлжлэх үйл явц хэрхэн өрнөдөг. Мэдээж шавхагддаг нөөц баялаг учраас хайран. Газар дэлхийгээ хайрлах хамгаалах хэрэгтэй. Нөгөө талаасаа Монголд жижиг, том ялгаагүй алт болгоныг ух гэж байгаа юм биш. Тодорхой хэмжээний шалгуур тавьж, хайгуулын ажлыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Таван жилийн өмнө Монгол Улсын нийт газар нутгийн 40 хувь нь лицензтэй байсан. Одоо нэг оронтой тоонд ороод ирсэн. Уул уурхайн салбарыг таван жилийн өмнөх замбараагүй байсан шиг одоо ойлгох нь учир дутагдалтай. Энэ цаг үе аль хэдийнэ өнгөрчихсөн. Уул уурхайн салбарыг хариуцлагатай болгох тал дээр анхаарах нь зүйтэй. Нөхөн сэргээлтэд өндөр шаардлага тавъя. Нийгмийн баялаг учраас орон нутгийн төсөвт төлж буй татвар бодит үр дүнгээ өгөөсэй. Тухайн сум, орон нутагт нь бидний төлж буй татвар хүрч, нутгийн иргэд үр шимийг нь хүртээсэй. Уурхай ажиллаж буй суманд татварын үр дүн гарах учиртай. Бид шалтгааны уг үндэс рүү орох ёстой.

Д.Жаргалсайхан: -Сүүлчийн хоёр жилийн хугацаанд манай эдийн засаг өндөр хувийн өсөлттэй гарлаа. 1996 оны манай төсвийн орлого 300 сая ам.доллар байсан бол өнөөдөр дөрвөн тэрбум ам.долларт хүрч байна. Эдийн засагт гарч буй ахиц, дэвшил өөрчлөлтийн 100 хувь биш юм гэхэд 80- 90 хувь нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулалттай шууд холбоотой. Үүний ашиг шимийг хүртээгүй нэг ч монгол хүн байхгүй. Цаашид энд хүрээд уул уурхайгаа зогсооё. Үүний оронд эрчим хүч, зарим хүний мөрөөдөөд буй технологийн салбараар төсвийн орлогоо бүрдүүлье. Энэ тохиолдолд уул уурхайг зогсоож болно шүү дээ. Өнөөдрийн хүрсэн түвшин ханасан уу гэвэл би ханаагүй гэж хэлнэ. Цаашид хэрэгцээ байна уу гэвэл байна. Үүнд төрийн оролцоо, дэмжлэг хэрэгтэй байна. Хөрөнгө оруулагчдын хариуцлагатай үйл ажиллагаа, Монгол Улсын нийгэм үүнийг ойлгож



бүх талаас нь дэмжиж ажиллах хэрэгтэй болов уу.

-Зах зээлийг өнөөдөр хэн зохицуулаад байна вэ?

Б.Бямбасайхан: -Хууль журмын хүрээнд хариулах байх л даа. Зах зээл гэдэг чинь тухайн барааг үйлдвэрлэдэг нөхөр, барааг хэрэглэгч хоёрын хоорондын харилцаа. Үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэх хүн байхгүй бол зах зээл байхгүй. Бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг хүн байхгүй бол бас болохгүй. Энэ хоёрын хооронд нарийн зохицуулалт явдаг. Хууль батлаад хуулийнхаа хүрээнд байвал боломжийн байна. Надад байхгүй юмыг тэр хүнээс авна, тэр хүнд байхгүй юмыг надаас авна гэсэн харилцаа. Үүнийг нэг болохоор эдийн засаг, эсвэл улс төр, ард түмэн гэж яриад байвал харилцааг булингартуулах талтай.

Д.Жаргалсайхан: -Манай төр бүхнийг шийддэг, зөвшөөрөл олгодог хуучин нийгмийнхээ үе рүү эргэж хальтирч ороод байгааг дахин хэлмээр байна. Нэг дарга нь би шийднэ, зохицуулна гэдэг. Хувь хүний асуудлыг төр шийдэх гээд байна шүү дээ. Үүнээс болоод иргэд миний өмнөөс, миний асуудлыг төр шийдээд өгөх юм байна гэсэн ойлголт авч байна. Төрийн үндсэн үүрэг гэж бий. Төр, зохицуулалт гэсэн асуудлыг тойруулаад дахиад л хөндөх хэрэгтэй болох байх. Миний хувьд өнгөрсөн хугацаанд олон хөрөнгө оруулагч, олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй уулзаж ярилцаж байсан. Олон газар очиж үзэж харлаа. Тэнд төрийн оролцооноос илүүтэй иргэдийн оролцоо өндөр байна. Жишээ нь, Швейцарь. Энэ оронд төрийн зохицуулалт гэхээс илүүтэй нийгмийн харилцаанд гарч буй шаардлагатай үүрэг, оролцоог хувийн салбар нь хариуцаж байна. Төр нь хяналт, зохицуулалтын оролцооноос татгалзсан байх жишээтэй. Олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллагуудын оновчтой тогтолцоог бий болгох талд нийгэм нэлээд идэвхтэй ажиллах хэрэгтэй.





Заавал төр хийх ёстой гэсэн хариулт өгч чадахгүй нь.

Б.Болд: -Зах зээлийн нууц гар гэдэг асуудлаас болоод байна. Зах зээлийн зарим сектор тодорхой зохицуулалттай байхаас өөр аргагүй байдаг. Миний ойлгож байгаагаар манайх либерал эдийн засаг руу явж байгаа. УИХ-ын дарга З.Энхболд гуай Төрийн өмчийн хорооны дарга байсан. Тэрбээр коммунизмын өмчлөлөөс салгаад хүн болгон баялагтай бол оо гээд өмч хувьчлалыг зохион байгуулсан.

Ардчилсан нам либерал үзэлтэй улс эх орныг бэлтгэсэн. Энэ үзэл бодлоо тууштай үргэлжлүүлээсэй. Хар залуугаараа коммунист үзэлтэй хэсэг бүлэг хүмүүс гарч ирж байгаа нь аюултай байна. Эндээс юмыг нь хурааж авъя. Тэгээд төрд өгье. Миний найз Төрөө компанийн захирал нь бол гэдэг ч юм уу. Амьдрал дээр ийм юм гаргахыг үгүйсгэхгүй. Зах зээл гэдэг өнөөдрийн хүн төрөлхтний бодож олсон хамгийн оновчтой загвар гэж байгаа. Оновчтой гэхээсээ бусдаасаа илүү нь. Тийм учраас энэ загвар дотроо Үндсэн хуулиар хамгаалагдсан хувь хүний өмчтэй холбоотой асуудлуудыг хүндэлдэг. Түүнээс биш, төрийн давамгайлсан өмчлөлтэй компани давуу эрх эдэлдэг байх ёстой биш. Адилхан өрсөлдөө. Гэхдээ өрсөлдөөн нь эрүүл байх ёстой. Жишээлбэл, яагаад заавал МИАТ бусад онгоцны компаниудаас илүү давуу эрхтэй байх ёстой юм. Эсвэл тодорхой салбаруудад зах зээлийн зохицуулалт гэдгийг нэг дарга гарч ирээд л зохицуулдаг, төрөөс төрсөн тэрбумтанг үргэлжлүүлэх нь бодлого биш. Энэ буруу байсныг бүгд хүлээн зөвшөөрөөд, ард түмэн сонголтоо хийсэн учраас зах зээлийн либерал эдийн засгийн бодлогоо үргэлжлүүлэн хөгжүүлээсэй. Тодорхой хэмжээний төрийн зохицуулалт зарим ялангуяа эмийн салбарт бол байх ёстой. Энэхүү зохицуулалтаа хэрхэн яаж хийх л чухал байна.

Нэг л өдөр гүйнэ, эрүүл саруул болно гэсэн итгэл үнэмшилтэй байгаа

-Энэ асуултаа Болд захиралд хандаж тавья. “Алтан Дорнод Монгол” компанийн тухайд гадаадын иргэнээс монгол захирлуудын гарт шилжиж ирсэн үндэсний аж ахуйн нэгж. Өр ширтэй, шүүхтэй байнга “найзалдаг” гээд олон муу нэр сонссон компани. Харин өнгөрсөн жилээс гэрэл гэгээтэй мэдээлэл дуулдах боллоо. БОНХЯ-ны дэргэдэх Иргэний зөвлөл танайхыг Нөхөн сэргээлтийн шилдэг компаниар тодруулсан. 24 тэрбум төгрөгийн татварыг улсад тушаасан байна. Уул уурхайн салбарт шилдэг компани болох зорилттой ажиллаж байгаа гэсэн. Харин та бүхний энэхүү идэвх зүтгэлийг төрөөс дэмжиж байна уу. Эсвэл татвараар дарамталж, ер нэхсээр сууна уу?

Б.Болд: -Шаварт унасан шарын эзэн гэгчээр бид өөрсдөө ийм асуудалтай компани руу давхиж орсон. Эргээд харахад амаргүй байж. Ер нь бол харанхуй зоригоор орсон. Тийм учраас хоёр жишээ яръя. Үхэлтэй тэмцэж буй комд орчихсон хүн байна гэж бодъё л доо. Тийм хүн ямар байх вэ та нар төсөөлж байгаа байх. Иймэрхүү байдалтай компани руу л явж орсон гэж бодож байгаа. Хаяа амь тариа хийдэг. Судас нь цохилохгүй. Харин тэр хүн маань өнөөдөр арай гэж хоёр таягтай явж эхэлж байна. Гүйж эрүүл болох хаа байсан юм. Шүүхийн маргаан, асуудал олон бий. Гэхдээ нэг л өдөр гүйнэ, эрүүл саруул, гоё болно гэсэн итгэл үнэмшилтэй байгаа. Монгол Улсын эрүүл чийрэг, үндэсний тэргүүлэгч уул уурхайн шилдэг аж ахуйн нэгж болохоор зорьж байна. Өнгөрсөн хугацаанд 700 гаруй хүнийг ажлын байраар хангасан. Бид алт гаргаж аваад түүгээрээ Америкт хаус худалдаж аваад, зугтаагаад амьдарсангүй. Эргүүлээд татварын өрүүд л төллөө.

Татварын өрийг газар доорх алт гэхээсээ илүү өөрийнхөө хувийн байшин, бүх босгосон хөрөнгөөсөө барьцаалаад төлөөд явж байна. Асуудал бол маш хүнд байгаа. Бидний зүгээс гурван үндсэн зарчим баримталдаг. Хариуцлагатай уул уурхай гэж хоосон ярихаасаа илүү яг гурван зүйл дээр хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Байгаль орчны нөхөн сэргээлт, Газар доорх баялгийг нийгмийн баялаг болгож хүртээх.

Нийгмийн хариуцлага бол дуусахгүй яриа. Төв аймгийн Заамарыг хүн болгон муугаар төсөөлдөг. Заамар гэдэг газрыг уул усаа тахиж шүтэж явдаг хүмүүс байгын дурсаж яваарай гэж хэлмээр

байна. Буянтай сайхан нутаг. Заамар нь Монгол Улсад 100 гаруй тонн алт өгсөн юм шүү. Оюутолгой, Тавантолгойг сураггүй шахам байхад “Алт” хөтөлбөрийн хүчинд манай төсөв 400 сая ам.долларт хүрсэн. Эдийн засгийг хүнд үеэс авч гарсан. Бид муу нэрнээс салмаар байна. Нөхөн сэргээлтээ үргэлжлүүлнэ. Өнгөрсөн жил 50 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн. Цаашид нөхөн сэргээлтээ чанаржуулна.

-Жаргалсайхан захирлын удирдсан “FSCO Mongolia” компани уул уурхайн зөвлөгөө, даатгал, байгаль орчинд ээлтэй бизнест хандсан үйл ажиллагаа явуулдаг. Таны эрхэлж буй бизнес ногоон хөгжилд юу авчрах вэ?

-Компани урт хугацаанд амжилттай ажиллахын тулд ямар чиглэлээр тууштай явах вэ гэдгээ шийдэх хэрэгтэй байдаг юм билээ. Бидний хувьд эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын үйлдвэрлэл рүү нэлээд гүнзгий орсон. Мөн “National life” буюу амьдралын даатгалын үйлчилгээ үзүүлж байна. Эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын үйлдвэрлэл Монголд ирээдүйтэй. Харамсалтай нь саяхныг хүртэл барилгын материалын үйлдвэрлэлийг Монголд дэмжих, тухайлбал, төр болон хувийн хэвшлийн зүгээс дорвитой арга хэмжээг аваагүй байна. Нөгөө талаар боломж нээж өгсөн. Манай “М солют” компани эрчим хүчний хэмнэлттэй магнизит хавтан үйлдвэрлэж, хэд хэдэн байшин барьж туршин, судалгаа хийсэн.

Судалгаагаар магнизитийн хавтангийн үйлдвэрлэлийн технологид суурилаад эрчим хүчний хэмнэлттэй бөгөөд боломжийн үнэтэй орон сууцтай болох технологийн шийдлийг бид олсон гэж бодож байна. Эрчим хүчний хэмнэлттэй байшин барихаас гадна өвлийн хамгийн хүйтэн саруудад тухайн байшингийн доторх дулааныг 20-22 хэмд барих зорилгоор Америкийн компанитай хамтран ажиллаж байна. Туршилтын ажил энэ хавар дуусах юм. Нарны модулиас дулаан үйлдвэрлэх бидний энэ ажил амжилттай болбол төрийн иргэдийг орон сууцаар, эрчим хүчээр хангах бодлоготой уялдаж энэ салбарт нэлээд том хувьсал авчрах болов уу хэмээн найдаж байгаа.

-“Ньюком” компани байгальд ээлтэй бизнесийн зарчмыг баримталдаг ногоон хөгжлийн үлгэр жишээ байгууллага. Танай компанийн цаашдын стратегийг сонирхож болох уу. Монгол Улсад ногоон эдийн засгийг хөгжүүлэх, бусад компаниудад үлгэр дуурайлал болох мөн туршлагаасаа хуваалцах чиглэлээр ямар төлөвлөгөөтэй байна вэ?

Б.Бямбасайхан: -Бид технологийн хөгжил асар хурдан өөрчлөгдөж буй орчинд амьдарч байна. Байгууллага ашигтай ажиллая гэж бодож байгаа бол хамгийн энгийн зүйл болох эрчим хүчний хэмнэлт хийх хэрэгтэй. Өдгөө Монголд Америк, Европ, Япон, Солонгосын бий болсон шинэ техник технологийг хэрэглэх боломжтой. Ийм орчинд бид амьдарч байгаа учраас байгаль орчиндоо ээлтэй технологийг эрчим хүчний үр ашигтай, бүтээмжтэй ашиглах нөхцөл бүрдэж байна. Энэ боломжийн анхдагч нь “Ньюком” компани. Монголд салхин цахилгаан станц бариад ашиглаж болох юм байна гэдгийг нүдээр харуулсан тохиолдолд энэ салбарт шинэ хүмүүс, дараа дараагийн шинэ төсөл орж ирнэ гэдэгт итгэлтэй байгаа. Үүний хажуугаар бид төслийн санхүүжилтээр Монголын эрчим хүчний салбарт цахилгаан станц барьж болдог юм байна гэдгийг харуулахыг зорьж байна. Гадна, дотнын хөрөнгө оруулагчид нийлээд дэлхийн хамгийн шилдэг техник технологийг Монголд нэвтрүүлж, монгол хүн үүнийг нь ашиглаж болно гэдгийг харуулбал зөв шийдэл.

Монголын бизнесийн хөгжил дараагийн шинэ үедээ ирж байна. Бид хоорондоо ч өрсөлдөнө. Гэхдээ гол нь шинэ өрсөлдөөний талбарт сайн ажиллах хүчинтэй, сайн технологитой байж бид ашигтай ажиллана. Мөн хариуцлагатай байх ёстой. Төр, засаг дэмжиж байна уу гээд Та асуугаад байна л даа. Төр, засаг дэмжих ёстой гэсэн ойлголт байх хэрэггүй. Хамгийн гол нь хуулиа барьж байна уу. Хууль журмандаа багтаад л ажиллаж байвал төр, засаг бидэнд хайртай байна уу, хайргүй байна уу ерөөсөө асуудал биш.

-Шинэчлэлийн Засгийн газарт үнэлэлт дүгнэлт өгөх болоогүй байна гэж ярьж байгаа ч тодорхой хугацаа өнгөрлөө. Шинэ Засгийн газрын бизнесийн салбарт хандах хандлага Та нарын хувьд хэр байна вэ. Мөнхийн завгүй та бүхэн үйл ажиллагаагаа явуулахдаа тэдэнд итгэж болохоор байна уу. Болж өгвөл нэг өгүүлбэрээр хариулбал сайн байна?

Д.Жаргалсайхан: -Тэд нэг гараараа бүтээгээд, нөгөө гараараа сөнөөгөөд байна.

Б.Бямбасайхан: -Бид нэг л улсад амьдарч байна. Монголын гэсэн нэг л эдийн засаг байна. Ирээдүйдээ итгэхгүй байвал хэцүү. Итгэж байна. Эдийн засаг маань жижиг учраас хурдан өсөж байна. Төр, засаг сайндаа эдийн засаг өсөөгүй. Ирээдүй ямагт гэрэлтэй байна.

Б.Болд: -Хэлбэр, агуулга хоёр битгий зөрөөсэй. Уриа лоозонгоор амьдармааргүй байна.

Эцэст нь өөрт төрөөд буй нэг санаагаа танай сэтгүүлээр дамжуулан төрийн түшээдэд уламжилмаар байна. АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэд хөрөнгө оруулалт, инновацийн чиглэлийн зөвлөлүүд ажилладаг. Энэ зөвлөлд том компаниудын удирдлагууд орж, бизнесийн асуудлыг төрд, Ерөнхийлөгчид хүргэж, санаа бодлоо хуваалцаж байдаг л даа. Тэгэхээр Ерөнхий сайдын дэргэд татвар төлөгчдийн төлөөллөөс бүрдсэн зөвлөл ажиллаж, бинесмэнүүдийн үгийг сонсож байвал ямар вэ. Сонин хэвлэлээр дуу хоолойгоо хүргэх нэг хэрэг. Тухайн салбарын асуудлаарх нэг зөвлөх бүгдийг мэдэхгүй шүү дээ. Тиймээс улиралдаа ч юм уу нэг удаа уулздаг, эсвэл Ерөнхий сайдад санаа бодлоо хэлдэг, тулгарч буй бэрхшээл, ололт амжилтаа ярьдаг зөвлөл байвал хувийн хэвшлийг хөгжүүлэх, бизнесийн орчныг сайжруулахад тустай юм болов уу гэж бодож байна.

Манай сэтгүүлийн редакцид хүрэлцэн ирж, санаа бодлоо хуваалцсан үндэсний компаниудын захирлууд та бүхэнд талархсанаа илэрхийлэхийн сацуу бизнесийн амжилт хүсье. ■

MADE IN MONGOLIA

ДУЛААНХААНЫ ЭВЭР НУМ



Нум сум урлаач С.Болдбаатар

Х.ХУЛАН

Бид энэ удаагийн “Made in Mongolia” булангаа орон нутгаас бэлтгэлээ. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан багийн Монгол түмний уламжлалт ёс заншил, түүх соёлын өв болсон нум сумын үйлдвэрлэлийг сонирхлоо.

Монгол орон баян. Төв Азийн цээжинд цохилох тус улсад газрын гүн дэх эрдэс түүхий эдээс илүү их баялаг хадгалаастай. Тэр нь Монгол түмний уламжлалт ёс заншил, түүх соёлын арвин өв юм. Манай сэтгүүл “Made in Mongolia” булангийн нийтлэлээ Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны “Хөвчит нум” ХХК-ийн зөвлөх Ж.Сүхбаатар, түүний хүү нум сум урлаач С.Болдбаатар нартай уулзаж бэлтгэлээ.

Нарны гэрэлд цацрах хөвөн цагаан цас, жавар шингэсэн цэнгэг агаар биднийг угтлаа. Дулаанхаан уулын өвөр, Ерөө голын хөвөөнд орших энэхүү тосгон одоогоос 51 жилийн өмнө байгуулагджээ. Өнгөрсөн сарын 22-ний ням гаригийн өглөө манай сэтгүүлийн сурвалжлах баг тус сумын нум сум урлаач Ж.Сүхбаатарынд очсон юм. Нутгийнхан нь түүнийг анддаггүй юм билээ. Тэрбээр 52 жил ханилсан гэр бүлийн хүн Ж.Даваагийн хамт биднийг дотно угтсан. Халуун цай ууж, орон нутгийн брэнд талх амталж, Дархан-Уул аймагт үйлдвэрлэсэн хиам, тавагтай идээгээр дайлуулах зуур орон нутагт үйлдвэрлэл хөгжжээ гэж бодогдов. Биднийг тэднийд очсон даруйд Сэлэнгэ аймгийн Баянгол сумаас хүүгээ дагуулсан зочин ирэв. Тэрбээр авч яваа нумаа гарган үзүүлж, юу нь болохоо байсныг мэдэхийг хүссэн юм. Сүхбаатар урлаач нумыг эргүүлж тойруулан хэсэг зуур шинжсэний эцэст “Шөрмөс нь хөндийрсөн байна” гэсэн онош тавилаа. Ирсэн зочны нэр алдрыг Х.Говь гэдэг бөгөөд 1957 оноос нум сум харваж байгаа аж. Тэрбээр Сүхбаатар гуайн тухай бидэнд хандаж “Үндэсний сурыг хөгжүүлэхэд гэр бүлээрээ хувь нэмрээ оруулж байгаа буянтай буурал байгаа юм. Улаанбаатараас энэ хүний нум сумны үйлдвэрлэлийг сурвалжлахаар ирсэн та бүхэнд талархаж байна” хэмээв. Монгол Улсад гарын 10 хуруунд багтах нум сум урлаач байдаг аж. Тэдний хоёр нь Дулаанхаанд амьдардаг. Улсын мэргэн Ж.Сүхбаатар, спортын мастер З.Баатар нар монгол нум сум урлах ухааныг хүүхдүүддээ зааж сургах их үйлийг хийсэн ахмадууд юм. Сүхбаатарын Болдбаатарын нум сумны урланд зочиллоо.

Эвэр элэгтэй, шөрмөсөн артай нум

“Хөвчит нум” компанийн урлан багийн Захиргааны байрны хажууд байрлах аж. Урлангийн зууханд гал дүрэлзэн асна. Өрөөний голд модон ширээнүүд байрлуулжээ. Дээр нь урлаж буй нум, янгирын эвэр, хусны үйс, бодын шөрмөс, тасын өд, хайч, цавуу тавиастай. Биднийг

урландаа хүлээж авсан Болдбаатар нум хийх талаар тайлбарлаж өгсөн юм. Уламжлалт монгол нум сумыг мал, амьтны түүхий эд ашиглан гар аргаар хийсээр иржээ. Үүнд, үхэр, янгирын эвэр, бод малын шөрмөс, хусны үйс, хулс ордог. Ан амьтны гаралтай түүхий эдээр хийдэг тул нум сум хувиралттай /мал, амьтны гаралтай түүхий эдүүдийн физик чанар өөрчлөгддөг/, байдаг. Монгол нум сумын онцлог нь чухам үүнд оршино. Нумын гурван бие буюу гол бүтцэд эвэр, хулс, бодын шөрмөс ордог аж. Дэлхийн олон орны нум сумтай харьцуулбаас манай нум шөрмөстэйгээрээ ялгардаг. Тийм ч учраас эвэр элэгтэй, шөрмөсөн артай нум гэж хэлдэг. Нум сум харвахаас өмнө нумаа "эвшээлгэдэг" нь учиртай. Эвшээлгэнэ гэдэг нь нумынхаа хатуу, зөөлнийг нь тохируулж чангаахыг хэлж байгаа аж. Энэхүү үйл нь шөрмөсний физик чанар алдагдахаас сэргийлж байгаа гэсэн үг. Сүхбаатар гуай сумны хүнд, нумны хатуу зөөлөн, хүний бяр чадал тэнцэж байж харваач болдог тухай ч хуучилсан.

Нум сум урлахад ордог ихэнх түүхий эдийг дотоодоосоо базаадаг. Харин хулсыг Хятадаас авдаг байна. Нэг нуманд 12-13 төрлийн материал ордог бөгөөд чимхлүүр ажил ихтэй. Түүхий эдээ бэлдэж нум сум хийхэд 4-6 сарын хугацаа зарцуулах нь ч бий. Нааж, зүйх гээд нарийн ажиллагаатай учраас тэр. Хулс, эвэр хоёрыг наагаад хатсаны дараа шөрмөсийг нь тавьдаг. Наалт наанадаж дөрвөөс зургаан сарын дотор хатдаг. Ер нь бол бүтэн нэг жил болж байж гүйцэд хатах үйл явц явагддаг. Нумыг удаан хатаах тусмаа хамгийн сайн бат бэх болдог гэж Болдбаатар ярив. Үйлдвэрлэлийг голдуу сэрүүний улиралд явуулах нь тохиромтой аж. Учир нь бүх материал амьтны гаралтай тул зун түүхий эдийн олдоц муугаас гадна хэт халуунд нум хатдаггүй талтай. Тухайлбал, шөрмөсийг мах бэлтгэлийн үеэр "Махимпэкс"-ээс 2900 төгрөгөөр худалдаж авдаг байна. Гэвч сүүлийн үед ченжүүд шөрмөсийг их хэмжээгээр авч, Япон руу гаргах болсон нь нум сум урлаачдын хувьд түүхий эдийн хомсдол үүсгэж болзошгүй юм. Японд бодын шөрмөсийг боловсруулж тансаг зэрэглэлийн хоол хийдэг байна. Янгирын эврийн олдоц ч гэсэн сүүлийн үед муудсан гэнэ. Иймд янгиртай газрын харваачдаас эвэр авч, оронд нь нум сум авах маягаар хамтрах болсон байна. Нэг нум бэлдэхэд нэг кг орчим шөрмөс, янгирын хос эвэр, тас шувууны өд ордог аж. Сумаа улиас, хус, бургасаар гэхчлэн олон төрлийн модоор хийж болох ч эднийх голдуу улиасаар урладаг. Эвэр, шөрмөсийг наахдаа малын арьс, туруугы найрлагатай цавуу ашигладаг байна.

Түүнчлэн нум сумны үйлдвэрлэлд хүний оролцоо их. Шөрмөс урах ажлыг л гэхэд нэгээс хоёр хүн хийнэ. Эврээ хөрөөдөх, халаах, тэгшлэх ажлыг мөн хоёр хүн гүйцэтгэнэ. Дамжлага, чимхлүүр ажил ихтэй энэхүү үйлээр хийсэн нум сум бүр бэлэн бүтээгдэхүүн болдоггүйг ч Болдбаатар учирлав. Эвэр хэт элэгдэж, гэмтсэн, эсхүл буруу хөрөөдсөн бол дахиж хийхээс аргагүйд хүрдэг аж. Жишээ нь, бодын шөрмөсийг урахад нэлээд эв дүй шаардана. Эвгүй татвал тасардаг тул эвийг нь олж урт уртаар нь таслах хэрэгтэй гэнэ. Ажлын оргил үеэр зургаан хүн ажиллах бөгөөд бусад үед түүхий эдээ боловсруулах зарим ажлыг гэрээр хийдэг аж. Орчин үед техник, технологи өндөр хөгжиж байгаа ч нум сум урлан бүтээх ажлын хамгийн багаар бодоход 70 хувь нь заавал гар аргаар бүтэх ёстой гэж Сүхбаатар гуай өгүүлсэн. Одоогийн байдлаар эднийх бүтээгдэхүүнээ 90 хувь гар аргаар хийж байна. Үнийн хувьд дөрвөн сумтай нумыг 400 мянгаар, хоромсог саадагтай гоёлын нум сумыг 600 мянган төгрөгөөр хийж байна. "Хөвч нум" компани жилдээ 60-70 нумын захиалгыг аймаг, орон нутаг, жуулчны байгууллага, тэр ч байтугай гадаадаас авдаг байна. Орос, Америк, Франц, Германаас ч захиалга ирэх нь бий.

Нум сум хөгжлийн гурван үеийг дамжжээ

Эрийн гурван наадмын нэг болсон Монгол үндэсний сур харваа нь Хүннүгийн үеэс үүсэлтэй. Ан ав







хийж, хоол тэжээлээ бэлдэх, агнасан ангийн арьсаар дээл хувцаа хийж өмсөх байдлаар үүссэн түүхтэй. Хүннүгийн үед Монголын урчууд нумаа эвэр элэгтэй, шөрмөсөн артай хийдэг болжээ. Түүнчлэн сумаа өдтэй болгосон. Ингэснээр нумын хүч чадал нэмэгдэж, сум нь өмнөхөөсөө хол явдаг болсон байна. Нум сум хөгжлийн гурван үеийг дамжсан байна. Эхний буюу хүй нэгдлийн үед ан хийдэг байж, дараа нь эх орноо батлан хамгаалах, эр цэргийн зэвсэг болсон. Харин хожим энх цагийн бүтээн байгуулалтын үед спортын хэрэгсэл болж, 1960 оноос өргөнөөр хөгжсөн. Эмэгтэйчүүд энэ үеэс л сур харваанд оролцдог болжээ. Манайд халх, урианхай, буриад гэсэн гурван төрлийн харваа байдаг гэж Сүхбаатар гуай сонирхуулсан юм. Халх харваг 75 метрээс, буриад, урианхай харваг 40 метрээс харвана. Эдгээрийн нум нь адил, сумнууд нь харин өөр байдаг аж.

Төрийн ордонд залсан нум

Сүхбаатар гуай хүү Болдбаатарын хамт хоёр жил хагасын хугацаанд уртаараа хоёр метр 50 см нум, нэг метр 50 см хэмжээний урттай (ердийн нумын урт нь хоёр метр 30 см, сум нь метр байдаг) сум урлажээ. Үүнийгээ 2002 онд Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулан, Төрийн ордонд хүндэтгэлтэйгээр залсан аж. Тэд Чингисийн үед нум сумаа шүтэж, төрийн цагаан сүлдний дэргэд тахидаг байсан ёс заншлаас санаачилсан байна.

Сүхбаатар гуай Дорнод аймгийн Халх сумын уугуул, Сэлэнгэ аймгийн суугуул хүн. Тэрбээр хөдөлмөрийн гараагаа Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Мод боловсруулах комбинатад зүсэх машинистаар эхлүүлж байжээ. Мөн тэрбээр үндэсний сурын харвааг үе залгамжлан харваж ирсэн удмын зургаа дахь үеийн харваач. Түүний ач, зээ нар эдүгээ найм дахь үеийнхэн болсон ажээ. Тэрбээр зах зээлийн шилжилтийн үед нум сум урлах ухааныг хойч үедээ дэлгэрүүлэн үлдээх үүднээс Бугант тосгоны захирагчийнхаа үүрэгт ажлыг хүлээлэн өгсөн гэдэг. Ийнхүү 1995 онд “Эвэр нум” нөхөрлөлийг Шаамар сумын Дулаанхаан тосгоны гуравдугаар багт байгуулсан түүхтэй. Ж.Сүхбаатар гуай “Эвэр нум” нөхөрлөлөө 2002 оноос “Хөвчит нум” ХХК болгон өргөтгөж, хүүБолдбаатартаа өвлүүлэн өгч тэтгэвэртээ суужээ. Гэсэн ч тэрбээр компанидаа зөвлөх хийж, 1964 оноос хойш Сэлэнгэ аймгийн Үндэсний сурын товчооны даргаар улиран сонгогдон ажилласаар. Эднийх өнгөрсөн хугацаанд хүүхдийн болоод том хүний, бэлэг дурсгалын 1000 орчим нум үйлдвэрлэсэн байна. Мөн нумаас гадна сум, товх, хайгуул, хөвч зэрэг дагалдах хэрэгслийг хийдэг. Монгол Улсад нум сум харвах ёс заншил өргөн дэлгэрч, үндэсний үйлдвэрлэл өргөжин хөгжих болтугай. ■



Фотог Э.Зоригт

Улсын мэргэн Ж.Сүхбаатар



Дулаанхаан дахь нум сумын урлан

БИЗНЕСМЭН БИЧИЖ БАЙНА

ЭДИЙН ЗАСГАА НӨАТ-ИЙН АЮУЛААС АВАРЦГААЯ

Т.ЯНЖИВ /“Био агро” ХХК-ийн захирал/

...Нэгэнт байгуулагдан ажиллаж байсан компани, аж ахуйн нэгжүүд жил бүр доройтон аажимдаа үүдээ хаахад хүрэх нөхцөлийг НӨАТ нэртэй борлуулалтын орлогын албан татвар бий болгожээ...

Нэмүү өртөг капиталын хуримтлал бий болгодог нь үнэн. Нэмүү өртөгийн ачаар эдийн засгийн эрх чөлөөнд хүрэхийн тулд зах зээлийн нийгмийг монголчууд бид сонгосон билээ. Гэтэл энэ эрх чөлөөг бидэнд бас л олгосонгүй.

Борлуулалтын орлогын 10 хувьтай тэнцэх НӨАТ-тай байна гэдэг нь борлуулалтын бүх орлогоо 100 хувь нэмүү өртөг гэж үзэж байж түүнээс хувилж авсан татвар гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, 1000 төгрөгийн зардлаар 1200 төгрөгийн үнэтэй шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ гэж үзвэл нэмэгдсэн өртөг нь 200 төгрөг, 10 хувийн НӨАТ нь 20 төгрөг. Гэтэл НӨАТ 200 төгрөгөөс биш, 1200 төгрөгөөс 10 хувиар НӨАТ гэж авахаар 120 төгрөг болж, авах ёстой татвараас зургаа дахин их татвар авч байгаа юм. Ийнхүү борлуулалтын орлогын өөр хаана ч байхгүй шинэ татвар зохиосон атлаа НӨАТ гэж огт өөр нэр өгсөн нь хачирхалтай. Харамсалтай нь энэ буруу хуулиас болж зах зээл жам ёсоор хөгжих хөгжлийнхөө 20-иод жилээ алдаад байна.

Нэмүү өртгийн тодорхойлтод таваар мөнгөний харилцааны цикл (М-Т-М’) хоорондын мөнгөний нэмэх зөрүүг (М’-М) нэмүү өртөг гэж тодорхойлсон байдаг нь дээрх тооцоо зөв болох нь харагдаж байна.

Амьдрал дээр борлуулалтын орлогын 10 хувьтай тэнцэх тийм их нэмэх зөрүү гарах нь ховор үзэгдэл. Энэ татвар нь худалдаа үйлдвэрлэлийн бүх хүрээг хамарснаараа бидний ярих дуртай дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт гэдэг үзүүлэлттэй утга дүйцэх тийм их тоо. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 10, 15 хувь хүрдэг улс орон гэж байдаг бил үү. Эндээс дүгнэвэл нэмэгдсэн өртөгийн албан татвар гэж нэрлэж авч байгаа энэ татвар онолын хувьд ч буруу, тоо хэмжээний хувьд ч үндэслэлгүй хэт өндөр татвар.

Нэмүү өртөг үйлдвэрлэж амжаагүй байтал НӨАТ нэрээр үйлдвэрлэгдсэн нэмэгдсэн өртгөөс нь хэд дахин өндөр татвар авч шинээр үүсч ядаж байгаа аж ахуйн нэгжүүдээ нураачихаад, ард иргэдээ хоосруулчихаад улс гэрээ яаж байгуулах гэж байгаа юм бэ.

НӨАТ бусад оронд байдаг нь үнэн боловч капитал 200-300 жил хөгжиж, үйлдвэрлэх хүчний хөгжил нь хэт үйлдвэрлэлийн хэмжээнд хүрсэн өндөр хөгжилтэй улс орнуудад хэт үйлдвэрлэлийн хямралаас сэргийлэх фонд байгуулах, бага ашигтай олон жижиг үйлдвэрлэлийг нэгтгэх томруулах зорилгоор “босго” болгож хэрэглэдэг онцлогтой татвар болохоос биш манайх шиг дөнгөж капиталын хуримтлал бий болгох, үйлдвэрлэл хөгжүүлэх, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах гэж ядаж байгаа эхлэлийн үед нь хэрэглэдэг татвар огт биш. Ашигаас нь борлуулалтын орлогын 10 хувьтай тэнцэх тэр их мөнгийг авахыг зөвшөөрөхгүй гэдгиийг мэдэж байсан болохоор ашиг тооцохоос нь өмнө борлуулалтаас нь аваад буцаагаад өртөгт нь шингээх мөлжлөгийн зальхаа арга хэрэглэсэн байна. Аж ахуйн нэгжүүдэд борлуулалтын орлогын 10 хувиас дээш ашигтай байж аж ахуй эрхэл гэсэн хэрцгий хатуу босго далд аргаар тулгасан байна.

Аж ахуй байгуулсан л бол ашигтай эсэхээс үл хамааран борлуулалтын орлогын 10 хувьтай тэнцэх НӨАТ заавал авч байгаа нь эхлэн аж ахуй эрхлэх боломжийг бараг хаасны дээр зориглон эхэлбэл шууд дампуурахаас өөр боломж олгосонгүй. Өөрөөр хэлбэл, эдийн засаг үүсч хөгжих боломжийг бараг бүрэн хаасан байна. Нэгэнт байгуулагдан ажиллаж байсан компани, аж ахуйн нэгжүүд жил бүр доройтон аажимдаа үүдээ хаахад хүрэх нөхцөлийг НӨАТ нэртэй борлуулалтын орлогын албан татвар бий болгожээ. Эндээс гарах ганц гарц нь төрд гарч, НӨТ нэрээр цугласан капиталын хуримтлалаас хөрөнгө оруулалт нэрээр тендерээр »

дамжуулж эргүүлж авах, өөр боломж олдоогүй байна. Ийм учраас бизнесменүүд төр рүү тэмүүлж, төрд цугласан олигархууд нэрийг олж олон түмний хараал ерөөлийг идэх болжээ. НӨАТ-өөс болж манай эдийн засгийн хөгжлийн гажиг өвчин үүсжээ.

Манайд НӨАТ авч болох үйлдвэрлэлийн цорын ганц салбар бий. Бурхнаас заяаж байгаль өөрөө нэмүү өртөг шингээсэн ашигт малтмалын салбарын олзворлолтоос 10 байтугай 50 хувь хүртэл татвар авсан ч болох юм. Жишээлбэл 2500 ккал\кг илчлэгтэй нүүрсний олзворлолтоос 10 хувь НӨАТ авдаг бол 10000 ккалл\кг илчлэгтэй нүүрсний олзворлолтоос 40-50 хувийн НӨТ авч болно.

Зэсийн 0.5 хувийн агуулгатай хүдрээс олзворлолт хийж байгаа “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэрээс 10 хувийн НӨАТ авч байгаа бол 2.5 хувийн агуулгатай Оюутолгой ордын олзворлолтоос 40-60 хувийн НӨАТ авч болох талтай.

Манай улсад нүүрлээд байгаа зовлон бэрхшээл бүхний эдийн засгийн үндэс нь НӨАТ юм. НӨАТ-ыг нийгмийн бүх хүрээнд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бүх салбарт хэрэглэснээр бизнесийн ашиг олох, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах боломжийг бүрэн хаасан төдийгүй нийгмийнхээ гишүүн бүрээс энэ татварыг авснаар орлогогүй ард иргэд улам бүр ядуурах үндсийг тавьжээ. Ийнхүү буруу, хуудуутай ганц хуулийн уршгаар улс орны хөгжил зогсонги байдалд орсон байна. Ойлгуулахын тулд жишээ татья.

1. “Буян”-гийн Жагаа ноолуур боловсруулах орчин үеийн үйлдвэр байгуулаад 15 жил болжээ. Одоо ноолуурынхаа үнийг дийлэхгүй эргэлтийн хөрөнгөгүй Хятадын доншуур ченжүүдэд дийлдээд сууж байгааг хар. Дотоодын хямд түүхий эдэд тулгуурласан, бүтээгдэхүүнээ бараг 100 хувь экспортод гаргадаг, хамгийн орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр өвч тоноглогдсон “Буян” компанийн үйлдвэр ийм байдалд байхад худал хэлж хулгай хийхгүйгээр аж ахуй хөтлөх юм бол дампуурахгүй амь тээх боломж бусад компаниудад олдоно гэж үү. Зах зээл хөгжсөн улс оронд ийм хэмжээний компани ганц хоёрхон жилийн дотор өр зээлээсээ салж, эдийн засгийн хараат байдлаа арилгаж, жил бүр бүтээгдэхүүний тоо хэмжээ өсч, тав, арван жилийн дараа дахин ийм үйлдвэр биеэ дааж байгуулдаг юм. Ийм хэмжээнд хүрсэн байх ёстой хугацаа өнгөрсөн байхад эргэлтийн хөрөнгө болох ноолуураа Хятадын ченжүүдэд булаалгаад сууж байгаа нь хаана ч байдаггүй борлуулалтын орлогын албан татвар буюу бидний андуурч нэрэлснээр НӨАТ-өөс болж байгаа юм.

2. Манайд НӨАТ үйлчлээгүй ганц салбар үлдсэн нь мал аж ахуйн салбар юм. Жил дараалсан ган зудад нэрвэгдэж байсан боловч мал 45 сая толгой болтлоо өсч манайдаа хэт үйлдвэрлэлийн хямралд анх удаа өртөж мах, ноос, ноолуур нь үнэгүйдэж байгааг хар. Хамгийн муу менежменттэй, их эрсдэл дагуулдаг, зах зээлээс алслагдсан, нөхцөл боломж хомс энэ салбарт яагаад хэт үйлдвэрлэл болтлоо өсөлт бий болов? НӨАТ үйлчлээгүйгээс тэр. Хэрэв бусад салбарт НӨАТ үйлчлээгүй байсан бол мал аж ахуйгаас хэд дахин их өсөлт гарсан байх нь ойлгомжтой юм. Эндээс л НӨАТ гэгчийн лай ланчигийг ойлгож болно.

Төр мал аж ахуйн хувьд макро эдийн засгийн бодлогоо зөв барьж энэ их мах, сүү, ноос, ноолуурыг гадаад зах зээлд борлуулах, дотоодод үйлдвэр байгуулж ашиглаж чадсан бол зөвхөн мал аж ахуйн салбар нь эдийн засгаа өөд нь татах төдийгүй малчид маань бүрэн хөл дээрээ босч чадах байлаа. Гэтэл одоо энэ салбарт юу болж байгаа билээ.

3. Арилжааны банкууд бараг толгой дараалан дампуурах болоод байсан хямралын үе саяхан. Учир

БИЗНЕСИЙН ЗӨВЛӨГӨӨ

ЭРСДЭЛ БА ҮНЭЛЭМЖ

НАЙЖИЛ ФИНЧ /Австралийн Сиднейн Их сургуулийн профессор/

Бизнесийн салбарын удирдах албан тушаалтанд тавигдах үндсэн шалгууруудын нэг нь оновчтой шийдвэр гаргах чадвар байдаг. Чухал шийдвэр гаргах шаардлага тулсан эгзэгтэй үе нь аливаа манлайлагчийн мөн чанарыг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, тухайн шийдвэрээс урган гарах эцсийн үр дүнг урьдчилан тооцоолж чадах эсэх нь амжилт гаргах чадварлаг нэгэн эсвэл уналтад хөтлөгдөх хүн алин болохыг тодорхойлох торгон мөч юм.Иймээс л томоохон шийдвэр болгоны цаана бизнесийн бодит дүн шинжилгээ хэрэгтэй байдаг. Энэ нь тухайн компанийн өмнө тулгарсан сонголтуудыг бүрэлдэхүүн хэсгээр нь ангилан ялгах, дүгнэж цэгнэхэд оршино.

Бодит дүн шинжилгээ хийх чадвараа хөгжүүлэх нь компанийн ерөнхий удирдлагын хувьд бүхий л томоохон шийдвэр гаргахад



нь мөнөөх л НӨАТ. Гүйлгээнийхээ орлогын арав, арван таван хувийг төрд НӨАТ хэлбэрээр өгчихсөн банк өгсөн НӨАТ-аа эргүүлж олж авахын тулд сар бүрийн 0,8 хувийн хүү нэмж тогтоохгүй бол дампуурах нь ойлгомжтой. Дээр нь иргэдийн хадгаламжийн хүү, хувь нийлүүлэгчдийн ашиг, байгууллагын өөрийн зардлаа нэмэхээр банкны хүү бага байх үндэсгүй. Өндөр хүүтэй зээлийг хэн авч ямар үр дүнд хүрэх болж байна. Ийм нөхцөлд НӨАТ-өөс болж банкууд дампуурах нь аргагүй, зээлжих боломжгүй эдийн засаг доройтох нь гарцаагүй, Дорой эдийн засагтай улс орны иргэд нь ядуурч элгээрээ мөлхөхөөс яалтай.

Монголын эдийн засгийг сул дорой байлгах НӨАТ-ийн бодлогын хэрэгжилт бусад ямарч хуулиас илүү бүр дөнгөж төрсөн хүүхдийн живхнээс өтөл болоод өнгөрч байгаа өтгөс буурлуудын толгой дээр нь тавьдаг хадаг хүртэл бүх хэрэглээнд нь НӨАТ-ын 10 хувийг авч чадаж байна. Энэ чөтгөрийн хуулиас өөр ямар ч хууль Монголд ингэтлээ үйлчилж байсныг хараагүй юм байна.

Харин ганц зүйл үлдсэн нь ард иргэдээсээ НӨАТ нэрээр авсан төрийн том капитал, түүний төлөөх тэмцэл нь сандал ширээ, албан тушаал, эрх мэдэл, авлига, хээл хахууль болж хэзээ мөдгүй тэсрэх дөхсөн дарьтай торх болон хувирлаа. Төрийн эрх мэдэл олж авсан тэр ховорхон азтай хүмүүс хөрөнгө оруулалт нэрээр тендерээр дамжуулж хагарталаа баяжиж олигархи үүсэх шимтэй хөрс боллоо. Вьетнам, Камбож, Лаос, Хятад гэх мэт шинээр үсрэнгүй хөгжиж байгаа улс оронд энэ татвар байдаггүй.

Эдийн засагчид аа, эрдэмтэд ээ ! НӨАТ-ийн талаар өргөн судалгаа явуулж улс орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахыг уриалж байна. Хөгжлийн тулах цэг, хөдлөх хөдөлгүүр нь болсон бизнесмэнүүд ээ! Төрд гарсан зарим бизнесийн төлөөлөл зөвхөн өөрсдийн хар амиа хоохойлж татварын өршөөлийн хууль батлаад 6.0 тэрбум ам.долларын өр цайруулаад сууж байна. Бид улс гэрээ мартаж ингэж хувиа хичээж болохгүй. Мөлжлөгийн далд хэлбэр болсон НӨАТ- ыг үл тэвчье. ■

ашиглагдах хоёр төрлийн чухал ойлголтыг суурь болгон ашиглахаас ихээхэн шалтгаалдаг. Эрсдэл ба үнэлэмж. Тус хоёр хэсэгт сонголтынхоо мөн чанарыг зааглаж өгөхгүй аваас бизнесийн манлайлагчид тодорхойгүй нөхцөл байдалд орох тэр тусмаа эдийн засаг эмзэг үед илүү хүнд байдалд “унахад” хүрдэг.

Эрсдэлээ бүрэн үнэлнэ гэдэг шийдвэр гаргалтын оргил цэг. Мэдээж аливаа бизнесийн шийдвэрийн боломжит сөрөг талуудыг олж харах амар биш. Ухсан нүхэнд унах нь тодорхой байсан ч сөрөг үр дагаврыг урьдчилан харж, бодитоор үнэлэх нь эрсдэлийг даах, даваад гарах чухал хүчин зүйл юм.

Өөрт учирч болох аюулд хэт анхаарлаа хандуулалгүйгээр эрсдэлийг тодорхойлж, үнэлж сурах нь бизнесийн салбар дахь манлайлагчдыг хэтийн зорилгодоо хүрэх алсын хараа бүхий сонголт хийх чадвартай болгодог.



Мөн манлайлагч хүн бизнесийн салбарт ажиллахад тэргүүн зэргийн ач холбогдолтой ямар асуудлуудад анхаарал хандуулах ёстойг эрсдэлийн нөгөө тал буюу үнэлгээг хийх явц чиглүүлж өгдөг. Хувийн амжилт болон шинэ санаачилгын алинаас нь үүдэлтэйгээс үл хамааран үнэлэмжээ тодорхойлох нь бизнесийн амжилтын алтан суурь юм.

Дээр дурдсан хоёр ойлголт дээр Сиднейн Их сургуулийн Бизнесийн сургууль дахь санхүүгийн удирдлага суурилдаг.

Дэлхий даяар тус салбарын хурдацтай өөрчлөлт нь өнөөдрийн бизнес эрхлэгчдээс боломжит сонголтуудынхаа үнэ цэнэ, ач холбогдлыг нарийвчлан тодорхойлох чадвартай байхыг шаардаж байна. Тэдний зүгээс болзошгүй эрсдэлийг үнэлэх чадвар, мэдлэгтэй байхын зэрэгцээ цаг нь ирэхэд зөв шийдвэр гаргах бүрэн чадамжтай байх шаардлага тулгарч буй. Тийм учраас стратеги төлөвлөлтийн салшгүй хэсэг болсон энэ хоёр асуудалд бид ач холбогдол өгдөг. Оновчтой шийдвэр гаргалтын суурь болсон уг хоёр ойлголтыг хэрхэн бодит дүн шинжилгээ хийхэд ашиглах вэ гэдэгт анхаарч ажиллаад байгаа юм.

Тогтмол өндөр бүтээмж бүхий үр дүнг хэрэглэгчид болон хувьцаа эзэмшигчиддээ түгээх нь манлайлагчийн шинж юм. Урт хугацааны тогтвортой амжилтад нарийн судалгаа, бүрэн бэлтгэлгүйгээр мөн санхүүгийн менежментийн зарчмын нарийвчилсан ойлголтгүйгээр хүрнэ гэдэг боломжгүй. ■

“Mongolian Economy” сэтгүүл энэ удаагийн “Өрхийн төсөв” булангаараа Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан багийн дундаж болон ядуу амьралтай иргэдийн орлогын эх үүсвэр болон зарцуулалтыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн V хорооны ижил түвшний амьдралтай өрхийн сар шинийн төсөвтэй харьцуулан хүргэж байна.

ӨРХИЙН ТӨСӨВ

“Дэгжин” орлоготой даржин амьдрал



Цэвэлмаагийнх сарын 500 гаруй мянган төгрөгийн орлоготой ч нэн ядуу ангилалд багтдаг

Фотог Зохиогч

Э.ЗОРИГТ

Овог, Нэр: Ц.Батболд
Ам бүл: 4
Өрхийн сарын дундаж орлого:
550 мянган төгрөг

Баярын ширээний ууц
250 мянган төгрөг

Хэвийн боов
42 мянган төгрөг /21 ширхэг/

Сар шинийн бэлэг
Авдаггүй

Тавгийн чихэр
Нийт үнэ: /30.000 төгрөг/
Нэгжийн үнэ дунжаар: /5000 төгрөг/

Төрөл: Төрөл бүрийн чихрээс холиод зургаан килограмм

Ундаа: Авдаггүй

Зууш
Нийт үнэ: 40.000 төгрөг
Төрөл: Өргөст хэмх, алаг салат, хиам,

Хоол
Нийт үнэ: 100.000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/:
Хонины гулууз мах 80.000 төгрөг.
Төрөл: Бууз

Архи
Нийт үнэ: 60.000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/: 6000 төгрөг
Төрөл: “Хараа” архи

Гэрэл муутай навтгар байшингийн зүүн талын хир даг болсон орон дээр үс нь даахирч, хувцас нь халтардсан 60 гаруй насны эмгэн бодол болон суух. Түүнийг Цэвэлмаа гэдэг. Нийслэлийн Хан-уул дүүргийн V хорооны иргэн. Цус харвасан тэрбээр ярьж, явж чадахгүй хүний гарт оржээ. Зургаан жил үйл, үг хоёргүй хорвоогийн өдрийг тоолон сууна. Тэрбээр том хүү Батболд бага, охин Лхагвасүрэн, түүний найман настай охины хамт амьдардаг. Лхагвасүрэн бүсгүй төмөр замын ослын улмаас зүүн гаргүй болж хөдөлмөрийн чадвараа алджээ. Харин Батболд татаж унадаг өвчтэй гэх шалтгаанаар мөн л эрхэлсэн ажилгүй. Тиймээс улсаас Батболд, Лхагвасүрэн нарт группын мөнгө гэж тус бүр 103 мянган төгрөг сардаа өгдөг байна. Мөн ээжийнхээ тэтгэврийн 240 мянга, улсаас өгч буй хүүхдийн 20 мянган төгрөг. Хашааны түрээс болох 30 мянган төгрөг гээд сард дунджаар 520 орчим мянган төгрөгийн орлоготой тус өрх нэн ядуу ангилалд ордог байна. Ядуу учраас тэдэнд улиралдаа нэг удаа 25 кг шуудай гурил, үхрийн мах, хүүхдийн нэмэлт тэжээл гээд бас бус зүйл Хорооноос нь өгчихнө. Батболд “Түмэн олныхоо буянд болж л байна. Гэхдээ бид өөрсдөө байгаа хэдээ зөв зарцуулж чадахгүй юм аа. Энэ Лхагвасүрэн хамаг мөнгөө хүүхдэдээ тоглоом авах нэрийдлээр үрчихнэ. Ах нь хааяа балгана. Тэгээд халамжийн хэдээ тавиад туучихна. Муу ээжийнхээ тэтгэврийн хэдээр л болж байна даа” гэсэн юм. Түүнээс долоо хоногтоо хэдэн удаа архи уудаг талаар асуухад “Ах нь 3-4 удаа бол уучихдаг. Нэг уухдаа хоёр шил юм бол зоолттой. Халуурвал тэгээд цаашаа явчих үе бий” гэсэн юм.

Даржин орлоготой дэгжин амьдрал

Овог, Нэр: Б.Батмандал
Ам бүл: 4

Өрхийн сарын дундаж орлого:
220 мянган төгрөг

Баярын ширээний ууц
50 мянган төгрөг
Төрөл: Хонины дал, дөрвөн өндөр

Хэвийн боов
30 мянган төгрөг /15 ширхэг/

Сар шинийн бэлэг
250 мянган төгрөг /Дунджаар нэг хүнд 3-5 мянган төгрөг/

Тавгийн чихэр
Нийт үнэ: 40.000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/: 7.000 төгрөг
Төрөл: Төрөл бүрийн чихрээс холиод зургаан килограмм

Зууш
Нийт үнэ: 50.000 төгрөг
Төрөл: Өргөст хэмх, алаг салат, хиам, майнеоз

Хоол
Нийт үнэ: 120.000 төгрөг
Төрөл: Бууз
Нэгжийн үнэ дунжаар: Хонины гулууз мах-100.000 төгрөг.
"Алтан тариа" дээд гурил 25 килограммтай-19 мянган төгрөг/

Архи
Нийт үнэ: 50.000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/: 15.000 төгрөг



Өдөр бүр гурилтай шөлнөөс өөр хоол иддэггүй гэдгийг нь мэдэхгүй хүнд Батмандалынх ядуу гэх ангилалд тохирохоороргүй харагдах ажээ

Сарын 220 мянган төгрөгийн орлоготой Б.Батмандалынх нийгмийн дундаж давхаргад багтдаг гэнэ. Эхнэр, охин, ээжийн хамт амьдардаг түүнд дээрх мөнгө ёстой аманд ч үгүй хамарт ч үгүй л байлтай. Батмандалын ээж Н.Соёлчимэг "Манай гэр орныг хүмүүс хараад "Танайхаас дор амьдралтай айл олон байна. Өрхийн орлогоо нуулаа" гээд байдаг. Бага орлоготой айл цэвэрхэн, аминдаа арчаатай амьдарч болдоггүй юм шиг байна. Ядуу ангилалд багтах гээд бохир заваан суух ёстой биш биз дээ" гэсэн юм. Үнэхээр тэднийх гэрэл гийсэн цэмцгэр айл. Нийслэлийн Хан-Уул дүүргийн V хорооны оршин суугч Батмандал түүний гэргий Мөнхзаяа хоёулаа их сургуулийн оюутан. Гэхдээ Батмандал зуны гурван сард геологийн ажил хийгээд хоёр биеийнхээ төлбөрийг олчихдог гэнэ. Хороонд ажилладаг ээжийнхээ сарын 120 мянган төгрөгийн цалин, гэрийн эзний группын 103 мянган төгрөгөөр тэд өдөр тутмын амьжиргаагаа болгодог. Мөн Соёлчимэгийн тусдаа гарсан гурван хүүхэд нь өвлийн нүүрс түлээг нь ээлжээр буулгаад өгчихдөг ажээ. Батмандал "Манай хороонд сарын 600-700 мянган төгрөгийн орлоготой мөртлөө ядуу ангиалалд ордог айл олон бий. Хүмүүс харахдаа тухайн айлын өнгө үзэмжийг хараад л энэ айл ядуу, дундаж гээд дүгнээд байх шиг. Уг нь багахан орлогоо хүргэх гэж байгаа хэдийгээ дэмжээд өгвөл нийгмийн амьдрал арай л хурдан дээшлэхсэн. Гэтэл манайхан эсэргээрээ байх шиг" гэв. Өдөр бүр гурилтай шөлнөөс өөр хоол иддэггүй гэдгийг нь мэдэхгүй хүнд тэд үнэхээр ядуу гэх ангилалд тохирохоороргүй харагдах ажээ.

Залхуу хүнд ялалт үгүй



Хөдөлмөрч хүн хөдөөд ч сайхан амьдарч болдог аж

Хангай нутаг цасанд дарагдаж, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан багийнхан нэг л ажин түжин. Хүйтэн өвөл, хүн ам цөөтэй газар нутаг болоод ч тэр үү, уйтгар төрүүлэм чимээ, аниргүй. 90-ээд он хүртэл Мод бэлтгэлийн үйлдвэрийн дамжин өнгөрүүлэх тосгон гэгдэж байсан Дулаанхааныхан хувьчлалын шуурганаар хөсөр хаягдсан гэхэд хилсдэхгүй. Тус багийн өндөр настан Ж.Даваа “Энд амьдрал ч хэцүү дээ хэцүү. Хөгшчүүлийн тэтгэвэр, халамжийн мөнгө харж л амьдарч байх шив дээ” хэмээн харамсангуй өгүүлсэн. Хамгийн сүүлийн судалгаагаар 479 өрх 1579 байгын оршин суугчтай эл нутагт эрхэлсэн ажилгүй залуучууд гудамж “хэмжиж”, зарим нь сархад хүртчихээд хөлчүүрхэх аж. Гэхдээ энд бусаддаа үлгэр дуурайлал болохуйц өрх айл цөөнгүй бий. Тэдний нэг нь Б.Энхболдынх юм. Тэрбээр “Амьдрал гэдэг хичээл зүтгэл дээр ургадаг цэцэг. Тэр тусмаа хөдөөгийн бид зогсолтгүй л хөдөлмөрлөх хэрэгтэй. Би гудамжинд таарсан тахир хадаасыг ч цуглуулдаг. Хүн тэгж л амьдарна” гэсэн юм. Өдгөө тэднийх Дархан-Уул аймагт дэлгүүр, дугуй засвар түрээслүүлдэг. Хувираа нум сум хийж, буудал ажиллуулж, гэрийнхээ хажууд жижигхэн хүнсний дэлгүүр нээжээ. Гэхдээ энэ бүх ажлыг гэрийн эзэн Энхболд л амжуулдаг байна. Дэлгүүрийн төлбөр тооцоо, өрхийн төсөв гээд ээжийн бүх үүргийг гүйцэтгэдэг гэрийн эзэн нутаг усандаа алдартай хөдөлмөрч нэгэн ажээ. Түүний уриа нь “Залхуу хүнд ялалт үгүй”. Түүний гэргий “Би чинь төрийн хар хүн. Төрийн сангийн төлөөлөгч гээд чухам л завгүй. Харин миний хань энэ гэрийг айлын дайтай авч яваа юм. Хоёр хүүхдээ төлбөртэй сургуульд сургаж байна. 3-4 хувийн байшинтай. Гурван хүнийг ажлын байраар хангасан. Энэ бүхэн чинь миний нөхрийн л ач тус” гэв. Залхуурч суух дургүй гэрийн эзэн маань өөртөө бас л нэг шинэ ажил олсон гэнэ. Тэр нь дулаарахаар блок цохих. Энхболд “Хүмүүс манайхыг баян, цатгалан гээд л байдаг. Хөдөө нутагт ажил хийлээ гээд амьдрал учиргүй сайхан болчихгүй. Цахилгааны төлбөр, цалин мөнгө тавих, хэдэн хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулах гээд хэдэн төгрөг цааш нь хийх гэсээр байтал олсон хэд маань дуусчихдаг. Дээрээс нь хүн олсныхоо зоргоор үрдэг бололтой юм. Урьд нь талх бариад л идчихдэг байсан бол одоо үйлдвэрийн боорцог л иддэг болсон байна ш дээ” гэж хуучлав. Харин удахгүй болох Цагаан сарын төсвөө Энхболд дараах байдлаар гаргажээ.

Овог, Нэр: Б.Энхболд
Ам бүл: 5

Өрхийн сарын дундаж орлого:
700-800 мянган төгрөг

Баярын ширээний ууц
500 мянган төгрөг /хоёр талын эцэг, эхэд тус бүр ууцны мах авч өгөх/

Хэвийн боов
18 мянган төгрөг /9 ширхэг/

Сар шинийн бэлэг
Авдаггүй

Тавгийн чихэр
Нийт үнэ: 40.000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/: 20.000 төгрөг/
Төрөл: Зөөлөн чихэр

Зууш
Өөрсдийн дарсан төрөл бүрийн ногоо

Хоол
Нийт үнэ: 60.000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/: Хонины мах 40.000 төгрөг. “Алтан тариа”-н дээд гурил 19 мянган төгрөг

Архи
Нийт үнэ: 50.000 төгрөг
Нэгжийн үнэ дунжаар: 25.000 төгрөг
Төрөл: Янз бүр

Бусад
100.000 төгрөг
Төрөл: Золгооны мөнгө

15 настай “сангийн сайд”

Навтгар байшинд өвлийн жавар хургажээ. Гэрийн баруун орон дээр 70 гаруй насны өвгөөөр эр хэдэн жилийн шороо тоосонд дарагдаж, ямар өнгөтэй нь үл мэдэгдэх ноорхой хөнжилдөө биеэ хураан хэвтэнэ. Энэ бол Дулаанхаан багийн иргэн А.Чулуунбатынх. Хүйтэн гэрт угаал үйлдэж байсан Мөнхзул охин хүний бараанаар биеэ засаж, ор дэрээ янзлах нь эгээл том хүн гэлтэй. Нутаг усныхан нь энэ гэр бүлийнхээ төсвийг наймдугаар ангид сурдаг түүнийг барьдаг гэсэн юм. Ах нар нь түүнийг цаашлуулж “сангийн сайдаа” гэж дууддаг гэнэ. Мөнхзул “Өвөөгийн тэтгэврийн 385 мянган төгрөгөөр л бүгдийг болгож байна. Тэрбээр “Ах нар ажилгүй болохоор дэм болдоггүй юм” гэлээ. Чинбаатар, Сайнжаргал, Сайнтөр гэх 22-43 насны харчууд гэртээ алга. Хаачсаныг нь тодруулахад, Мөнхзул мөрөө хавчсан юм. Цус харвасан өвөөгөө асрах, хичээлээ давтах, оройн хоолоо хийх гээд гэрийн эзэгтэйн үүргийг гүйцэтгэх гээд жаахан биенд ажил мундахгүй. Хар нялхаараа өнчирсөн охин өдөр хоногийг өлөн зэлмүүн өнгөрөөж байна. Түүний дуртай амттан нь жүрж жимс гэсэн. Харин тэр дуртай амттанаа хэзээ идсэнээ санахгүй байсан юм. Удахгүй болох Цагаан сараар өвөөгийнхөө тэтгэврийнхээ хэдээр юу авахаа тэр хичээлийнхээ дэвтрийн арын хуудаст төлөвлөжээ.

Овог, Нэр: А.Чулуунбат
Ам бүл: 5

Өрхийн сарын дундаж орлого:
385 мянган төгрөг

Баярын ширээний ууц
Авдаггүй

Хэвийн боов
18 мянган төгрөг /9 ширхэг/

Сар шинийн бэлэг
Авдаггүй

Тавгийн чихэр
Нийт үнэ: 5000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/: 5000 төгрөг

Хоол
Нийт үнэ: 100.000 төгрөг
Нэгжийн үнэ /дунжаар/: Хонины мах 80.000 төгрөг. “Алтан тариа”-н I гурил 15 мянган төгрөг/



Сэлэнгэ аймгийн Дулаанхаан багийн А.Чулуунбатынх

ДЭД БҮТЭЦ

75

Б.ҮҮРИЙНТУЯА

Их зөгнөөч Нострадамус “Төмөр могой дэлхийг орооно” хэмээн зүүдний тайлалдаа дурдсан байдаг. Европоос эхтэй төмөр замын сүлжээ хүмүүний амьдралын нэгэн хэсэг болсоор даруй 500 гаруй жилийг үдэжээ.



Төрийн бодлогоор хөгжин дэвших учиртай энэ салбар Монгол Улсад үүсэн хөгжөөд цөөнгүй жилийг ардаа орхисон ч өнөөдрийг хүртэл улс төрийн талцалын “золиос” болж буй нь харамсалтай. Өргөн, нарийн царигийн аль нь вэ гэх асуулт Монголд дэндүү улстөржөөд байх шиг. Хэн нэгний саналыг дөвийлгөх бус эдийн засаг, геополитикийн бодлогод үндэслэн Монгол Улсын ирээдүйд тус салбарын дэвшил хэрхэн нөлөөлөхийг урьтал болгох нь чухал буй за.

Өргөн гэхийн учир

Газрын гүн дэх баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулахад хайгуул, олборлолтоос гадна хэрэглэгчдийн гарт хэрхэн хүргэх вэ гэдэг чухал. Уул уурхай эрчимжиж, ашигт малтмалын салбарын хөгжил Монголын ирээдүйг тодорхойлж буй өнөө үед дэд бүтэц, тэр дундаа төмөр замын салбарын үүрэг тэргүүлэх ач холбогдолтой. Энэ эгзэгтэй мөчид төрийн түшээд төмөр замын өргөн, нарийн цариг хэмээн хоёр тийш харж суугаа нь ажлыг хойш татах нөхцөл болж байгаа юм. Одоо манайд ашиглагдаж буй өргөн царигтай төмөр зам нийт ачаа эргэлтийн 90 хувийг нугалж байна. Гэвч энэ нь эдийн засгаа өөд татахад хангалтгүй бөгөөд шинээр төмөр зам барих шаардлагыг бий болгож буй. Төрийн бодлогодоо өргөн царигтай барина гээд заачихсан байхад хуулийг гууль болгох гэж зүтгэх нь өрөөсгөл. Иймд хуульдаа захирагдан, бодлогын хүрээнд суурь бүтцийг барих ажлыг эхлүүлэх нь зөв болж таарах. Ийнхүү 2011 онд “Шинэ төмөр зам” төслийн ТЭЗҮ-ийг УИХ-д танилцуулж, батлуулсан. Харин их бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх эхний ээлжийн 55 сая ам.долларыг саяхан шийдвэрлэсэн билээ. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал асан Б.Батзаяа “Шинэ төмөр зам төсөл эдийн засгийн хувьд үр ашигтай төсөл гэдгийг онцлон хэлэхийг хүсэж байна” хэмээсэн удаатай. Тэгвэл энэ төслийн үр өгөөж чухам юунд оршиж буйг дурдах нь зүйтэй. Нэгдүгээрт, төсөл хэрэгжсэнээр экспортын шинэ гарцууд бий болох аж. Нийт 1800 км төмөр зам барих уг төслийн цэвэр үнэлгээг 660 сая ам.доллар (2011 оны байдлаар), эдийн засгийн өгөөж нь 13.5 хувьтай байна гэсэн тооцоог гаргасан байдаг. Шаардлагатай нийт хөрөнгө оруулалтын 60 хувь буюу гурван тэрбум ам.долларыг зээлийн санхүүжилтээр, үлдсэн 40 хувь буюу хоёр тэрбум ам.долларыг өөрийн хөрөнгийн санхүүжилтээр зохион байгуулахаар төлөвлөжээ. Харин хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацааг тээвэрлэлтийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 9.4 жил гэж тусгасан бөгөөд 2020 он гэхэд тус төслийн хүрээнд жилд дунджаар 47 сая тонн коксжих, 20 сая тонн эрчим хүчний зориулалттай нүүрс тээвэрлэх аж. Батзаяагийн хэлснээр зүүн тийш төмөр зам баригдсанаар Монгол Улс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээ гаднын зах зээлд нийлүүлэх, цаашлаад экспортын гарцуудыг төрөлжүүлэх ач холбогдолтой гэнэ. Тэрбээр “Бодлогын баримт бичгийн нэг гол үзэл санаа бол уул уурхайн бүтээгдэхүүнийг далайн зах зээлд хүргэх явдал” хэмээн тус төслийг сайшааж байжээ. Сайншандын аж үйлдвэрийн паркаас гарах бүтээгдэхүүнийг дэлхийд таниулах уг төслийн хэрэгжилтийн эхний шат 400 сая орчим ам.долларын санхүүжилт шаардах юм. Уг бүтээн байгуулалтын хамгийн том сөрөг талыг экологийн сүйрэл дагуулна гэх яриа бий. Харин өргөн царигтай төмөр замд “хайр зарлагсад” тэрхүү асуудлыг шилжүүлэн ачих битүүмжилсэн бункер барих замаар шийдвэрлэнэ гэдгээ хэлсэн. Хэдий асуудлыг цэгцлэх боломж өргөн ч энэ нь эргээд нүүрсний үнийг тэнгэрт хадаах нөхцөл болох вий гэж болгоомжлох хүмүүс байна. Иймээс нүүрсний хамгийн том худалдан авагч болох Хятад руу шууд явах зам тавих нь үр дүнтэй хэмээх хэсэг ч бий. Тухайлбал, саяхан Дэлхийн банкны эдийн засагч нар сэтгүүлчидтэй уулзах үеэр энэ талаар байр суурийг нь сонирхоход “Ямар ч тохиолдолд Монгол Улсын хувьд гол хэрэглэгч зах зээл рүүгээ чиглэсэн төмөр зам тавин нь зөв” хэмээсэн.

267

Бидний нарийн гэж нэрлэх 1435 мм царигтай төмөр замыг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд тавих асуудлаарх улс төрийн маргаан шинэ оны эхний сарыг донсолгов. Бизнес ашигтай байж бизнес болдог. Эл зарчмын дагуу харьцангуй хямд өртөгөөр буюу 232 сая орчим ам.долларааар босох нарийн царигтай төмөр замын тухай яриа өрнөсөөр хоёр Засгийн газрыг үзээд буй. Харин “Өргөн царигтай төмөр зам барина” гэх заалт бүхий “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг 2010 онд баталсан билээ. Гэвч

“Тэгэхдээ арилжааны чиглэлийн төмөр зам барихын тулд Засгийн газар саналаа УИХ-д оруулж батлуулна” гэх нэмэлт заалтын дагуу нарийн царигтай төмөр замыг Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлд тавих саналыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн дарга асан М.Энхсайхан гаргаад байсан юм. Сэтгүүлчдэд дэлгэсэн түүний судалгаанд өргөн царигтай төмөр замаар нүүрс тээвэрлэх нь эдийн засгийн хувьд зарлага ихтэйгээс гадна байгальд төдийгүй иргэдийн эрүүл мэндэд хортой хэмээжээ. Тухайлбал, 20 сая тонн нүүрс ачиж, буулгахад 500 мянган тонн нүүрсний тоосонцор агаарт “хөвөх” аж. Эдийн засгийн үүднээс авч үзвэл хямд өртөгөөр босох уг зам нь хилийн зааг дээрх ачааллыг багасгаж, үр ашгаа хурдан өгнө хэмээн сайшаагдсан ч урд хөршийн зах зээлээс хэт хамааралтай болохоос гадна Сайншандын аж үйлдвэрийн парк түүхий эдгүй болох эрсдэл дагуулна гэх болгоомжлол байна. Энэ талаар УИХ-ын гишүүн Ц.Нямдорж “Нарийн царигтай төмөр зам барих нь баялгаа Хятадад алдана. Энэ нь үндэсний аюулгүй байдалд халтай гэж ярих утгагүй. Монгол Улсын гааль, хилийн цэрэг гээд хяналт тавих байгууллагууд бий. Ийм хөнгөн зүйлээр иргэдийн толгойг эргүүлж, хувийн ашиг, сонирхлоо хөөж байна” хэмээн ярьсан.

Ойрын ашгаа харвал нарийн царигаар төмөр зам барих нь ашигтай мэт боловч Сайншандын аж үйлдвэрийн паркын ирээдүй бас чухал гэдгийг санах хэрэгтэй болов уу. Стратегийн гэх газрын тосны салбар ОХУ-ын “эрхшээлд” байдаг. Харин эдийн засгийн хөшүүрэг болж буй уул уурхайн салбараа урд хөршийн зах зээлд атгуулах нь хэр зүйтэй вэ гэдэгт хүн бүр өөрийн дүгнэлтээ хийх буйз аа.

